НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

**ХҮҮ ТОРГУУЛИЙН ЭХ ҮҮСВЭРЭЭР ОРОН НУТГИЙН ТӨСӨВТ 351,095.22 САЯ ТӨГРӨГИЙН ОРЛОГО БҮРДҮҮЛЖ, ГЭМТ ХЭРГЭЭС УРЬДЧИЛСАН СЭРГИЙЛЭХ БОЛОН АВТОЗАМ ЗАСВАР, ШИНЭЧЛЭЛИЙН ЧИГЛЭЛЭЭР 28.1 ХУВИЙГ ЗАРЦУУЛСАН БАЙНА.**

**АУДИТЫН СЭДЭВ: ХҮҮ, ТОРГУУЛИЙН ОРЛОГЫН БҮРДҮҮЛЭЛТ, ЗАРЦУУЛАЛТ**

**АУДИТЫН КОД: НТАГ-2025/27-ШТА-ГА**

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дараах хаягаар авна уу.

**Нийслэл дэх Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Г.Нандинжаргал**
**Ахлах менежер Ч.Болд**
**Аудитын менежер Э.Мөнхмандах**
**Аудитын менежер Л.Саранбаатар**
**Ахлах аудитор Д.Дайриймаа**
**Ахлах аудитор З.Баярбилэгт**
**Аудитор М.Одгэрэл**
**Аудитор Ц.Ариунболд**
**Аудитор Г.Саянболд**
**Аудитор Б.Сайнбаяр**
**Аудитор Т.Гандолгор**
**Аудитор М.Өлзийхишиг**
**Аудитор Б.Уранчимэг**
**Аудитор Ц.Алтантуяа**
**Аудитор Б.Цэрэнхүү**

Улаанбаатар хот
2025 он

# МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ АУДИТОРЫН ТУШААЛ

2025 оны 12 сарын 31 өдөр Дугаар А/185 Улаанбаатар хот

## Аудитын тайланг баталгаажуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1 дэх хэсэг, 20 дугаар зүйлийн 20.1, 20.2, 20.4 дэх хэсэг, 29 дүгээр зүйлийн 29.1.9 дэх заалт, 29.3 дахь хэсэг, 33 дугаар зүйлийн 33.6 дахь хэсэгт заасныг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.“Хүү, торгуулийн орлогын бүрдүүлэлт, зарцуулалт”-д хийсэн гүйцэтгэлийн аудитын тайланг хавсралтаар баталгаажуулсугай.

2.Аудитын тайланг Улсын Их Хурлын Төсвийн байнгын хороо, Сангийн яаманд хүргүүлэхийг Гүйцэтгэлийн аудитын газар (Д.Энхболд), Нийслэлийн Засаг дарга, Нийслэлийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газарт тус тус хүргүүлэхийг Нийслэл дэх Төрийн аудитын газар (Г.Нандинжаргал)-т тус тус даалгасугай.

3.Аудитаар өгсөн зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5-д заасан хугацаанд, зөвлөмжийн биелэлтийг 2026 оны 11 дүгээр сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Сангийн сайд (Б.Жавхлан), Нийслэлийн Засаг дарга (Х.Нямбаатар) нарт тус тус зөвлөсүгэй.

4.Аудитаар өгсөн албан шаардлага, зөвлөмжийн мэдээллийг статистик мэдээнд бүртгэж Аудитын шийдвэрийн хэрэгжилтийн газарт хүргүүлэхийг Нийслэл дэх төрийн аудитын газар (Г.Нандинжаргал)-т, аудитаар өгсөн албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт тавьж, үр дүнг тооцож ажиллахыг Аудитын шийдвэрийн хэрэгжилтийн газар (Ч.Цэвэгдорж)-т тус тус даалгасугай.

5.Аудитын тайланг баталгаажуулснаас хойш 14 хоногт багтаан аудитын ажлын болон нотлох баримтыг архивын нэгж болгон Нийслэл дэх Төрийн аудитын газрын архивд хүлээлгэн өгөхийг Гүйцэтгэл, нийцлийн аудит хариуцсан ахлах менежер (Ч.Болд)-т үүрэг болгосугай.

6.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж, үр дүнг тооцож ажиллахыг Тамгын газрын дарга, тэргүүлэх аудитор (Б.Бундхорол)-д даалгасугай.

С.МАГНАЙСҮРЭН

Z:\Tushaal\2025\EA-In A Tushaal\1231 GAG-1.Docx

1525010005

Монгол Улсын Ерөнхий аудиторын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн 185 дугаар тушаалын нэгдүгээр хавсралт

## Агуулга


**Тайланг бэлтгэсэн:**

Нийслэл дэх Төрийн аудитын газрын Дарга, тэргүүлэх аудитор
Г.Нандинжаргал

Ахлах менежер(гүйцэтгэл, нийцлийн аудит хариуцсан)
Ч.Болд

Аудитын менежер
Э.Мөнхмандах
Л.Саранбаатар

Ахлах аудитор
Д.Дайриймаа
З.Баярбилэгт

Аудитор
М.Одгэрэл
Ц.Ариунболд
Г.Саянболд
Б.Сайнбаяр
Т.Гандолгор
М.Өлзийхишиг
Б.Уранчимэг
Ц.Алтантуяа
Б.Цэрэнхүү

2025 оны 12 дугаар сар

Тайланг ҮАГ-ын цахим сайтаас үзнэ үү.
www.audit.mn

*Аудитын тайлан, дүгнэлттэй холбоотой асуудлаар нэмж тодруулах утас: 325093, 70007734*

***Хаяг:***
*Соёлын төв өргөө, Г корпус, 5 давхар, Г.Амарын гудамж, 8 дугаар хороо, Сүхбаатар дүүрэг,*
*Улаанбаатар хот-14200*
*Монгол Улс*



Товчилсон үгийн тайлбар....3
Хүснэгтийн жагсаалт....4
Хавсралтын жагсаалт....4
Дүрслэлийн жагсаалт....4
Ерөнхий зүйл....5
Ерөнхий мэдээлэл....7
БҮЛЭГ 1. Хүү, торгуулийн орлогыг өмнөх оны гүйцэтгэл, сангийн яамнаас хянасан дүн зэргийг харгалзан төлөвлөсөн байна....8
БҮЛЭГ 2. Хүү,торгуулийн орлогыг орон нутгийн төсөвт төвлөрүүлэх төсвийн тухай хуулийн хэрэгжилт хангалтгүй байна....13
БҮЛЭГ 3. Хүү, торгуулийн орлогоос хуваарилсан хөрөнгийн 95.8 хувийг зориулалтын дагуу зарцуулсан байна....19
БҮЛЭГ 4. Хүү, торгуулийн орлогын бүрдүүлэлт, зарцуулалтад тавих хяналтыг хангалттай хэрэгжүүлээгүй байна....26
Аудитын дүгнэлт....30
Аудитын зөвлөмж....31
Холбогдох байгууллагын санал....32
Хавсралт 1 Улс, орон нутгийн төсөвт хүү, торгуулийн орлогын эзлэх хувь....33
Хавсралт 2 Аймаг, нийслэл, дүүргийн ИТХ-ын төсөв баталсан тогтоолд хүү, торгуулийн орлогыг тусгасан байдал (2023, 2024)..33
Хавсралт 3 ГХУСА-д төсөв батлаагүй болон дутуу тусгасан сумууд....34
Хавсралт 4 Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд баталсан төсвийг зориулалт бусаар зарцуулсан зөрчил (2023, 2024 он)....35
Хавсралт 5 Шилэн дансны цахим хуудсанд мэдээлэл оруулсан байдал....40

## Товчилсон үгийн тайлбар

| | |
|---|---|
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| БОУАӨЯ | Байгаль Орчин, Уур Амьсгалын Өөрчлөлтийн Яам |
| ГЕГ | Гаалийн Ерөнхий Газар |
| ГЗБГЗЗЕГ | Газар Зохион Байгуулалт, Геодези, Зураг Зүйн Ерөнхий Газар |
| ГХЗУСТХ | Гэмт Хэрэг, Зөрчлөөс Урьдчилан Сэргийлэх Тухай Хууль |
| ГХУСА | Гэмт Хэргээс Урьдчилан Сэргийлэх Ажил |
| ГХУСАЗЗ | Гэмт Хэргээс Урьдчилан Сэргийлэх Ажлыг Зохицуулах Зөвлөл |
| ГХУСАЗСЗ | Гэмт Хэргээс Урьдчилан Сэргийлэх Ажлыг Зохицуулах Салбар Зөвлөл |
| ЗГ | Засгийн Газар |
| ЗТЯ | Зам, Тээврийн Яам |
| ЗХУТ | Замын Хөдөлгөөний Удирдлагын Төв |
| ИТХ | Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал |
| МУ | Монгол Улс |
| МУЗГ | Монгол Улсын Засгийн Газар |
| НД | Нийгмийн Даатгал |
| НДЕГ | Нийгмийн Даатгалын Ерөнхий Газар |
| НЗД | Нийслэлийн Засаг Дарга |
| НТАГ | Нийслэл дэх Төрийн Аудитын Газар |
| НЦУГ | Нийслэлийн Цагдаагийн Удирдах Газар |
| НШШГГ | Нийслэлийн Шүүхийн Шийдвэр Гүйцэтгэх Газар |
| ОБЕГ | Онцгой Байдлын Ерөнхий Газар |
| ОНӨТҮГ | Орон нутгийн өмчит төсөвт үйлдвэрийн газар |
| ОУ | Олон Улс |
| СС | Сангийн Сайд |
| СТСХ | Санхүү Төрийн Сангийн Хэлтэс |
| СЯ | Сангийн Яам |
| ТАТХ | Төрийн Аудитын Тухай Хууль |
| ТЕГ | Татварын Ерөнхий Газар |
| ТТХ | Төсвийн Тухай Хууль |
| ТЦА | Тээврийн Цагдаагийн Алба |
| УБЕГ | Улсын Бүртгэлийн Ерөнхий Газар |
| УЕПГ | Улсын Ерөнхий Прокурорын Газар |
| ҮАГ | Үндэсний Аудитын Газар |
| ҮОМШӨ | Үйлдвэрлэлийн Осол, Мэргэжлээс Шалтгаалсан Өвчин |
| ЦЕГ | Цагдаагийн Ерөнхий Газар |
| ШШГЕГ | Шүүхийн Шийдвэр Гүйцэтгэх Ерөнхий Газар |
| ЭБАТ | Эрх Бүхий Албан Тушаалтан |
| ЭМДЕГ | Эрүүл Мэндийн Даатгалын Ерөнхий Газар |
| ЭЭХХЗГ | Эм Эмнэлгийн Хэрэгслийн Хяналт, Зохицуулалтын Газар |

## Хүснэгтийн жагсаалт


| Дугаар | Гарчиг | Хуудас |
|---|---|---|
| **Хүснэгт 1** | СЯ-аас хянасан хүү, торгуулийн орлогын төлөвлөгөө | 8 |
| **Хүснэгт 2** | СЯ-аас хянасан хүү, торгуулийн орлогын төлөвлөгөөг аймаг, нийслэлийн ИТХ өөрчлөлт оруулсан байдал | 9 |
| **Хүснэгт 3** | Хүү, торгуулийн орлогын төлөвлөлт, төвлөрүүлэлт | 10-11 |
| **Хүснэгт 4** | Эрх бүхий албан тушаалтны шийтгэл оногдуулсан байдал | 12 |
| **Хүснэгт 5** | Хүү, торгуулийн орлогын бүрдүүлэлт | 13 |
| **Хүснэгт 6** | Торгуулийн ногдуулалт, бүрдүүлэлт | 13-14 |
| **Хүснэгт 7** | Торгуулийн орлого бүрдүүлэлт | 14 |
| **Хүснэгт 8** | Хүүгийн орлого бүрдүүлэлт | 15-16 |
| **Хүснэгт 9** | Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын төсөвт батлагсан санхүүжилт | 17 |
| **Хүснэгт 10** | Хүү, торгуулийн орлогоос авто замын санд хуваарилсан санхүүжилт | 18 |
| **Хүснэгт 11** | Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажил болон автозамын сангийн зарцуулалт | 19 |
| **Хүснэгт 12** | ГХУСАЗСЗ-ийн төсвийн зарцуулалт | 19 |
| **Хүснэгт 13** | НД-ын хүүгийн хуваарилалт, зарцуулалт | 22 |
| **Хүснэгт 14** | Шилэн дансанд мэдээлэл оруулсан байдал | 25 |
| **Хүснэгт 15** | Цагдаагийн байгууллагаас 2017-2024 онд оногдуулсан торгуулийн үлдэгдэл | 28 |
| **Хүснэгт 16** | Эрх бүхий байгууллагуудаас хяналт хэрэгжүүлсэн байдал | 28 |
| **Хүснэгт 17** | Шийтгэлийн хуудасны тооцоо нийлсэн байдал | 29 |


## Хавсралтын жагсаалт


| Дугаар | Гарчиг | Хуудас |
|---|---|---|
| **Хавсралт 1** | Улс, орон нутгийн төсөвт хүү, торгуулийн орлогын эзлэх хувь | 33 |
| **Хавсралт 2** | Аймаг, нийслэл, дүүргийн ИТХ-ын төсөв баталсан тогтоолд хүү, торгуулийн орлогыг тусгасан байдал (2023, 2024) | 33-34 |
| **Хавсралт 3** | ГХУСА-д төсөв батлаагүй болон дутуу тусгасан сумууд | 34-35 |
| **Хавсралт 4** | Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд баталсан төсвийг зориулалт бусаар зарцуулсан зөрчил (2023, 2024 он) | 35-39 |
| **Хавсралт 5** | Шилэн дансны цахим хуудсанд мэдээлэл оруулсан байдал | 40 |


## Дүрслэлийн жагсаалт


| Дугаар | Гарчиг | Хуудас |
|---|---|---|
| **Дүрслэл 1** | УЕПГ-аас ЭБАТ-ны шийдвэрийг хүчингүй болгосон, өөрчлөлт оруулахаар дүгнэлт гаргасан байдал | 12 |
| **Дүрслэл 2** | Аймгуудаас ногдуулсан торгуулийн орлогын биелэлт | 14 |
| **Дүрслэл 3** | Торгуулийн орлого бүрдүүлэлт (байгууллагаар) | 15 |
| **Дүрслэл 4** | НД-ын хүүгийн орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл | 16 |
| **Дүрслэл 5** | Аймаг, нийслэл, дүүргийн ИТХ-ын төсөв баталсан тогтоолд хүү, торгуулийн орлогыг тусгасан байдал | 17 |
| **Дүрслэл 6** | Хүү, торгуулийн орлогын хуваарилалт | 17 |
| **Дүрслэл 7** | Зөрчлийн ангилал | 20 |
| **Дүрслэл 8** | Цагдаагийн байгууллагад бүртгэгдсэн зөрчлийн тоо | 24 |
| **Дүрслэл 9** | Хүү, торгуулийн орлого төвлөрүүлэгч зарим байгууллагуудын салбарын хэмжээнд ашиглаж буй мэдээллийн систем, программ хангамжийн талаар | 26 |
| **Дүрслэл 10** | Замын хөдөлгөөн, тээврийн хэрэгсэлтэй холбоотой зөрчлийг бүртгэж буй байдал. | 26 |

## ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

### Аудит хийсэн үндэслэл, бүрэн эрх

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, Монгол Улсын Их Хурлын Төсвийн Байнгын хорооны 2024 оны 05 дугаар тогтоол, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2024 оны "Аудитын жилийн төлөвлөгөө батлах тухай" А/108 дугаар тушаал, Нийслэл дэх Төрийн аудитын газрын 2025 оны "Гүйцэтгэлийн төлөвлөгөө"-г тус тус үндэслэн аудитыг хийж гүйцэтгэв.

### Аудитын зорилго, зорилт

Хүү, торгуулийн орлогын бүрдүүлэлт, зарцуулалтад гүйцэтгэлийн аудит хийж, дүгнэлт өгч зөвлөмж боловсруулан дүнг Монгол Улсын Их Хурал болон холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулахад аудитын зорилго чиглэгдсэн. Уг зорилгын хүрээнд дараах дэд асуудлуудад аудитыг чиглүүлэн хийж гүйцэтгэлээ.

- Хүү, торгуулийн орлогын төлөвлөлт нь хэрэгцээ шаардлагад нийцсэн эсэх;
- Хүү, торгуулийн орлого бүрдүүлэлтийг хууль, журамд нийцүүлэн төвлөрүүлсэн эсэх;
- Хүү, торгуулийн орлогын зарцуулалт үр дүнтэй эсэх;
- Хүү, торгуулийн орлогын бүрдүүлэлт, зарцуулалтад тавих хяналт үр дүнтэй хэрэгжсэн эсэх.

### Аудитын хамарсан хүрээ

Аудитад хүү, торгуулийн орлого төлөвлөх, бүрдүүлэх, зарцуулах, хяналт хэрэгжүүлдэг төрийн байгууллагуудын холбогдох чиг үүргийн хэрэгжилт, 2023, 2024 онд хүү, торгуулийн орлогыг бүрдүүлсэн байдал, түүний зарцуулалт, хяналт хэрэгжүүлсэн талаарх тайлан мэдээ, дансны хуулга, бусад нотлох баримт, материалыг хамруулсан.

### Аудитын арга зүй

Аудитыг гүйцэтгэлийн аудитын стандарт АДБОУС 100, 300, 400, 3000-3100, 4000-д нийцүүлэн боловсруулсан Монгол Улсын төрийн аудитын стандарт MNS 6817-5:2020 Гүйцэтгэлийн аудитын зарчим, MNS 6817-6:2020 Нийцлийн аудитын зарчим, MNS 6817-7:2020 Гүйцэтгэлийн аудитын стандарт, MNS 6817-8:2020 Нийцлийн аудитын стандарт, Монгол улсын Ерөнхий аудиторын А/106 дугаар тушаалаар баталсан 2020 оны "Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам"-ын дагуу аудитын зорилго, зорилт, асуудлын шинжилгээний асуултад хариулт өгөхөд шаардагдах нотлох баримт цуглуулах, баримтжуулах, тэдгээрийг нягтлан шалгах, дүн шинжилгээ, харьцуулалт, тулган баталгаажуулалт, түүвэрлэлт хийх, судалгаа явуулах арга зүйг ашиглах зэргээр аудитын хөтөлбөр, горим, асуудлын шинжилгээ, шалгах хуудасны дагуу ажлын баримт боловсруулан аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж боловсруулав.

### Аудитын арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудитын зорилттой холбоотой дараах хууль тогтоомж, дүрэм, журам, зааврыг шалгуур үзүүлэлт болгон ашиглав. Үүнд:

- ✓ Монгол Улсын Үндсэн хууль;
- ✓ Төсвийн тухай хууль;
- ✓ Төсвийн тогтвортой байдлын тухай хууль;
- ✓ Нийгмийн даатгалын багц хуулиуд;
- ✓ Татварын багц хуулиуд;
- ✓ Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль;

- ✓ Гаалийн ерөнхий хууль;
- ✓ Засгийн газрын тусгай сангийн тухай хууль;
- ✓ Автозамын тухай хууль;
- ✓ Зөрчлийн тухай хууль;
- ✓ Зөрчил хянан шийдвэрлэх тухай хууль;
- ✓ Улсын бүртгэлийн тухай хууль;
- ✓ Иргэний хууль;
- ✓ Банк, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, мөнгөн хөрөнгийн шилжүүлэг, зээлийн үйл ажиллагааны тухай хууль;
- ✓ Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль;
- ✓ Байгаль орчныг хамгаалах тухай хууль;
- ✓ Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хууль;
- ✓ Төрийн аудитын тухай хууль;
- ✓ Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль;
- ✓ Засгийн газрын 2023 оны 278 дугаар тогтоолоор баталсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”;
- ✓ Засгийн газрын 2020 оны 107 дугаар тогтоолоор баталсан “Гэмт хэргээс урьдчилсан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн ажиллах журам”;
- ✓ Засгийн газрын 2021 оны 135 дугаар тогтоолоор баталсан “Шийтгэлийн болон шийтгэлээс чөлөөлөх хуудасны маягт, хэрэглэх журам”;
- ✓ Сангийн сайдын 2013 оны 73 дугаар тушаалаар баталсан “Төсвийн санхүүжилтийн болон зарцуулалтын эрхийн тухай журам”;
- ✓ Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалаар баталсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”;
- ✓ Сангийн сайдын 2022 оны А/282 дугаар тушаалаар баталсан “Төсвийн зарлагын хэмнэлт, үндсэн үйл ажиллагааны нэмэлт орлогыг зарцуулах, тайлагнах, нягтлан бодох бүртгэлд тусгах, хяналт тавих журам”;
- ✓ Сангийн сайдын 2025 оны А/3 дугаар тушаалаар баталсан “Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам”;
- ✓ Бусад холбогдох хууль, тогтоомж, эрх зүйн актууд.

**Хүндрэл бэрхшээл:**

Төсвийн тухай хуулиар хүү, торгуулийн орлого нь орон нутгийн төсөвт төвлөрөх зохицуулалттай ч торгуулийн орлого төвлөрүүлэгч байгууллагууд улс, орон нутгийн төсөвт харилцан адилгүй төвлөрүүлдэг.

Сангийн яаманд байрших төсвийн орлогын дансуудыг тулгахад тухайн орлого төвлөрүүлсэн байгууллагууд тооцоо нийлдэггүй, төсөвт төвлөрч буй торгуулийн нэр, данс, хаанаас шилжүүлсэн нь тодорхойгүй байдлаас орлогыг нэгтгэх боломж хязгаарлагдмал байсан.

Төрийн сангийн хүү, торгуулийн дансанд хүү, торгуулийн орлогоос гадна татварын торгууль, алданги, хяналт шалгалтаар илэрсэн зөрчилд ногдуулсан төлбөрийн актын орлого төвлөрүүлдэг нь орлогыг ангилахад хүндрэл үүсгэсэн.

НТАГ-аас улсын хэмжээний байгууллагуудыг аудитад хамруулж шууд харилцахад байгууллагуудын түвшин хооронд ялгаа үүсэж хүндрэлтэй байсан.

## ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Төсвийн тухай хуулиар төсвийн орлого нь татварын болон татварын бус орлогоос, татварын орлого нь албан татвар, төлбөр, хураамжаас бүрдэх, татварын бус орлого нь тус хуулийн 23 дугаар зүйлийн 23.3[1]-т “*... торгуулийн орлого болон хууль тогтоомжийн дагуу төсөвт төвлөрүүлэх бусад орлого* ...”-оос бүрдэхээр хуульчилсан.

Төсвийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.7.2[2], 23.9.2[3]-д “аймаг, нийслэл, сум, дүүргийн татварын бус орлого нь ..... *хүү, торгуулийн орлого ...*-с бүрдэх”-ээр байна.

Хүү, торгуулийн орлогоос 2023, 2024 онд нийт 322,676.35 сая төгрөгийн орлого төвлөрүүлэхээс 361,173.77 сая төгрөгийн орлогыг төвлөрүүлсэн байна.

Дээрх орлогын 97.2 хувь буюу 351,095.22 сая төгрөгийг орон нутгийн төсөвт, 2.8 хувь буюу 10,078.54 сая төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлсэн байна.

Орон нутгийн төсөвт төвлөрсөн 351,095.22 сая төгрөгийн орлогоос гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд 55,911.40 сая төгрөг, авто замын санд 48,329.50 сая төгрөгийг хуваарилан зарцуулсан байна.

Харин "орон нутгийн төсвийн суурь орлого"-д 246,854.32 сая төгрөг буюу 70.3 хувь нь төвлөрч зарцуулагдсан байна.

Зөрчил шалган шийдвэрлэх эрх бүхий 9542 улсын байцаагчийн эрхтэй албан тушаалтан 65 салбарт харьяаллын дагуу зөрчлийг шалган шийдвэрлэж торгууль ногдуулж байна. *Тухайлбал: /ЦЕГ, ТЕГ, ГЕГ, УБЕГ, НДЕГ, Авто тээвэр, иргэний нисэх, боловсрол, эрүүл мэнд, хөдөлмөр, соёлын өв, эрүүл ахуй, мал аж ахуй гэх мэт/*

Аудитад орон нутгийн төсөвт төвлөрсөн орлогын бүрдүүлэлт, зарцуулалтыг бүрэн хамруулж, улсын төсөвт төвлөрсөн орлогын бүрдүүлэлтийг түүврийн хэмжээнд хамруулсан болно.

[1]23.3.Татварын бус орлого нь төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн төрийн болон орон нутгийн өмчид ногдох хувьцааны ногдол ашиг, төрийн болон орон нутгийн өмчийн эд хөрөнгийг ашигласны төлбөр, төрийн болон орон нутгийн өмчийг түрээсэлсний орлого, торгуулийн орлого, төсвийн байгууллагын туслах үйл ажиллагааны орлого, Засгийн газрын зээллэг, тусламж болон хууль тогтоомжийн дагуу төсөвт төвлөрүүлэх бусад орлогоос бүрдэнэ.

[2]23.7.2.орон нутгийн өмчийн эд хөрөнгийг ашигласны төлбөр болон борлуулсны орлого, хүү, торгуулийн орлого;

[3]23.9.2.орон нутгийн өмчийн эд хөрөнгийг ашигласны төлбөр болон борлуулсны орлого, хүү, торгуулийн орлого;

# БҮЛЭГ 1. ХҮҮ, ТОРГУУЛИЙН ОРЛОГЫГ ӨМНӨХ ОНЫ ГҮЙЦЭТГЭЛ, САНГИЙН ЯАМНААС ХЯНАСАН ДҮН ЗЭРГИЙГ ХАРГАЛЗАН ТӨЛӨВЛӨСӨН БАЙНА.

***Төсвийн тухай хуульд заасны дагуу хүү, торгуулийн орлогын төлөвлөгөөг хянуулсан байна.***

1.1. МУ-ын нэгдсэн төсвийн бүрэлдэхүүн хэсэг болох орон нутгийн төсвийг Төсвийн тухай хуулийн 4.1.27[4], 23.7.2, 23.9.2-т *"тухайн шатны төсөвт харьяалагдах ерөнхийлөн захирагчийн бүрдүүлж, хуваарилан зарцуулах төсөв гэж тодорхойлж, хүү, торгуулийн орлогыг орон нутгийн төсөвт төвлөрөх орлого"*-д хамаарахаар хуульчилсан.

1.2. Дээрх хуулийн 8 дугаар зүйлд заасны дагуу тухайн шатны төсөв захирагчийн жилийн төсөв, сар, улирлын хуваарийн тооцооллыг орон нутгаас боловсруулан, төсвийн суурь орлогын төлөвлөгөөг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хуулийн хугацаанд хүргүүлдэг байна.

1.3. Аймаг, нийслэлээс ирүүлсэн төсвийн хуваарь төлөвлөлтийг санхүү төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас хянаж, хуулийн хугацаанд төсөв хэлэлцэхэд өргөн мэдүүлснээр тухайн жилийн төсөвт бүрдүүлэх орлогын нэр төрлөөр баталдаг байна.

1.4. Орон нутгийн хэмжээнд хүү, торгуулийн орлогыг СЯ-аас 2023 онд 166,946.10 сая төгрөг, 2024 онд 123,667.80 сая төгрөг нийт 290,613.90 сая төгрөгөөр хянасан байна.

**Хүснэгт 1. СЯ-аас хянасан хүү, торгуулийн орлогын төлөвлөгөө** (сая.төг)

| № | Аймаг, нийслэл | Хүүгийн төлөвлөлт | | Торгуулийн төлөвлөлт | | Нийт | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | 2023 он | 2024 он | 2023 он | 2024 он | 2023 он | 2024 он | Дүн |
| 1 | Архангай | 2,495.90 | 508.70 | 900.00 | 1,176.40 | 3,395.90 | 1,685.10 | 5,081.00 |
| 2 | Баян-Өлгий | 345.30 | 113.60 | 1,100.00 | 1,500.00 | 1,445.30 | 1,613.60 | 3,058.90 |
| 3 | Баянхонгор | 750.70 | 47.60 | 1,680.00 | 1,680.00 | 2,430.70 | 1,727.60 | 4,158.30 |
| 4 | Булган | 2,389.00 | 595.70 | 900.00 | 1,000.00 | 3,289.00 | 1,595.70 | 4,884.70 |
| 5 | Говь-Алтай | 780.40 | 47.00 | 1,100.00 | 1,100.00 | 1,880.40 | 1,147.00 | 3,027.40 |
| 6 | Говьсүмбэр | - | - | 840.00 | 850.00 | 840.00 | 850.00 | 1,690.00 |
| 7 | Дархан-Уул | - | - | 1,200.00 | 1,300.00 | 1,200.00 | 1,300.00 | 2,500.00 |
| 8 | Дорноговь | 1,735.70 | 577.70 | 1,000.00 | 1,000.00 | 2,735.70 | 1,577.70 | 4,313.40 |
| 9 | Дорнод | 1,858.40 | 24.80 | 1,500.00 | 1,520.00 | 3,358.40 | 1,544.80 | 4,903.20 |
| 10 | Дундговь | 2,540.40 | 629.00 | 600.00 | 700.00 | 3,140.40 | 1,329.00 | 4,469.40 |
| 11 | Өвөрхангай | 3,734.80 | 1,069.90 | 1,300.00 | 1,550.00 | 5,034.80 | 2,619.90 | 7,654.70 |
| 12 | Өмнөговь | 1,036.60 | 433.70 | 3,000.00 | 3,000.00 | 4,036.60 | 3,433.70 | 7,470.30 |
| 13 | Завхан | 576.70 | - | 780.00 | 1,000.00 | 1,356.70 | 1,000.00 | 2,356.70 |
| 14 | Орхон | 4,467.50 | 420.10 | 1,450.00 | 1,450.00 | 5,917.50 | 1,870.10 | 7,787.60 |
| 15 | Сүхбаатар | 1,807.30 | 113.40 | 630.00 | 700.00 | 2,437.30 | 813.40 | 3,250.70 |
| 16 | Сэлэнгэ | - | - | 1,500.00 | 2,000.00 | 1,500.00 | 2,000.00 | 3,500.00 |
| 17 | Төв | 346.20 | 20.50 | 1,800.00 | 2,000.00 | 2,146.20 | 2,020.50 | 4,166.70 |
| 18 | Увс | 326.30 | - | 800.00 | 800.00 | 1,126.30 | 800.00 | 1,926.30 |
| 19 | Хөвсгөл | 1,924.50 | 485.40 | 950.00 | 1,100.00 | 2,874.50 | 1,585.40 | 4,459.90 |
| 20 | Ховд | 323.20 | - | 850.00 | 920.00 | 1,173.20 | 920.00 | 2,093.20 |
| 21 | Хэнтий | 2,257.90 | 426.20 | 800.00 | 1,150.00 | 3,057.90 | 1,576.20 | 4,634.10 |
| 22 | Нийслэл | 47,569.30 | 25,658.10 | 65,000.00 | 65,000.00 | 112,569.30 | 90,658.10 | 203,227.40 |
| | **Нийт** | **77,266.10** | **31,171.40** | **89,680.00** | **92,496.40** | **166,946.10** | **123,667.80** | **290,613.90** |

Эх сурвалж: Сангийн яам

[4]4.1.27."орон нутгийн төсөв" гэж аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, улсын болон орон нутгийн зэрэглэлтэй хот, тосгоны Зөвлөлөөс баталсан, тухайн шатны төсөвт харьяалагдах ерөнхийлөн захирагчийн бүрдүүлж, хуваарилан зарцуулах төсвийг;

1.5. Орон нутгаас ирүүлсэн хүү, торгуулийн орлого бүрдүүлэх саналыг 2023 онд өмнөх оноос 34,564.20 сая төгрөг буюу 26.0 хувиар нэмэгдүүлж, 2024 онд өмнөх оноос 43,278.30 төгрөг буюу 25.9 хувиар бууруулж төлөвлөжээ.

**СЯ-аас хянасан хүү, торгуулийн орлогын төлөвлөгөөг тухайн шатны ИТХ-аас бодит нөхцөл байдал, судалгаанд үндэслээгүй, харилцан адилгүй хувь хэмжээгээр өсгөж, бууруулан баталсан байна.**

1.6. Аймаг, нийслэл, сум, дүүргийн ИТХ-аас хүү, торгуулийн орлогын төлөвлөгөөг батлахдаа СЯ-аас хянасан дүнг нэмэгдүүлэх болон бууруулах байдлаар баталжээ.

**Хүснэгт 2. СЯ-аас хянасан хүү, торгуулийн орлогын төлөвлөгөөг аймаг, нийслэлийн ИТХ өөрчлөлт оруулсан байдал**

(сая.төг)

| № | Аймаг, нийслэл | Хянасан дүнг өсгөж / бууруулсан 2023 он | | Хянасан дүнг өсгөж / бууруулсан 2024 он | |
|---|---|---|---|---|---|
| | | Дүн | Хувь | Дүн | Хувь |
| 1 | Архангай | (549.99) | -16.2 | (0.03) | - |
| 2 | Баян-Өлгий | (861.16) | -59.6 | (312.65) | -19.4 |
| 3 | Баянхонгор | (310.02) | -12.8 | (397.52) | -23.0 |
| 4 | Булган | (748.76) | -22.8 | (930.27) | -58.3 |
| 5 | Говь-Алтай | 1,719.92 | 91.5 | 557.24 | 48.6 |
| 6 | Говьсүмбэр | 60.00 | 7.1 | 512.20 | 60.3 |
| 7 | Дархан-Уул | 400.00 | 33.3 | 200.00 | 15.4 |
| 8 | Дорноговь | (449.99) | -16.4 | (449.99) | -28.5 |
| 9 | Дорнод | (489.81) | -14.6 | (188.05) | -12.2 |
| 10 | Дундговь | (212.40) | -6.8 | 10,799.99 | 812.6 |
| 11 | Өвөрхангай | (1,845.95) | -36.7 | (1,229.03) | -46.9 |
| 12 | Өмнөговь | (963.36) | -23.9 | (1,298.21) | -37.8 |
| 13 | Завхан | (347.57) | -25.6 | (165.40) | -16.5 |
| 14 | Орхон | (4,467.50) | -75.5 | 2,936.72 | 157.0 |
| 15 | Сүхбаатар | (1,837.30) | -75.4 | 1,771.96 | 217.8 |
| 16 | Сэлэнгэ | (750.00) | -50.0 | (250.00) | -12.5 |
| 17 | Төв | (852.63) | -39.7 | (729.47) | -36.1 |
| 18 | Увс | 405.61 | 36.0 | 250.00 | 31.3 |
| 19 | Хөвсгөл | (1,637.70) | -57.0 | (699.95) | -44.1 |
| 20 | Ховд | (59.58) | -5.1 | 980.70 | 106.6 |
| 21 | Хэнтий | (945.99) | -30.9 | 185.06 | 11.7 |
| 22 | Нийслэл | 534.62 | 0.5 | 88,857.90 | 98.0 |

Эх сурвалж: Аймаг, нийслэлийн ИТХ-ын тогтоол

1.7. СЯ-аас хянасан нийслэлийн төсөвт төвлөрүүлэх хүү, торгуулийн орлогын дүнг Нийслэлийн ИТХ-аас 2023 онд 0.5 хувь буюу 534.62 сая төгрөг, 2024 онд 98.0 хувь буюу 88,857.90 сая төгрөгөөр нэмэгдүүлж баталсан байна.

1.8. Дараах аймгуудын ИТХ-аас хүү, торгуулийн орлогын төлөвлөгөөг 7.0-813.0 хувиар нэмэгдүүлэн баталсан байна. Үүнд:

*2023 он:*

- *Говь-Алтай аймаг 1,719.92 сая төгрөг буюу 91.0 хувь;*
- *Увс аймаг 405.61 сая төгрөг буюу 36.0 хувь;*
- *Дархан аймаг 400.00 сая төгрөг 33.0 хувь;*
- *Говь-сүмбэр аймаг 60.00 сая төгрөг буюу 7.0 хувь;*

*2024 он:*

- *Дундговь аймаг 10,800.0 сая төгрөг буюу 813.0 хувь;*
- *Сүхбаатар аймаг 1,771.96 төгрөг буюу 218.0 хувь;*
- *Орхон аймаг 2,936.72 сая төгрөг буюу 157.0 хувь;*
- *Ховд аймаг 981.0 сая төгрөг буюу 107.0 хувь;*
- *Говь-сүмбэр аймаг 512.20 сая төгрөг буюу 60.0 хувь;*
- *Говь-Алтай аймаг 557.24 сая төгрөг 49.0 хувь;*
- *Увс аймаг 250.00 сая төгрөг 31.0 хувь;*
- *Дархан аймаг 200.00 сая төгрөг 15.0 хувь;*
- *Хэнтийн аймаг 185.06 сая төгрөг 12.0 хувиар тус тус нэмэгдүүлэн баталсан.*

1.9. Хүү, торгуулийн орлогын төлөвлөгөөг нэмэгдүүлсэн нь дараах шалтгаантай байна. Тухайлбал:

- *Дундговь аймаг 10,800.0 сая төгрөгөөр нэмэгдүүлсэн нь аймгийн татварын газраас 2023 онд ААНБ-д хийсэн хяналт, шалгалтаар ногдуулсан 8,702.7 сая төгрөгийн торгуулийн орлогыг тайлант онд төвлөрүүлэхээр төлөвлөсөн;*
- *Нийслэл болон Говь-Алтай аймаг өмнөх оны хүлээгдэж буй гүйцэтгэлээс шалтгаалан ИТХ-аас хүү, торгуулийн орлогыг нэмэгдүүлсэн;*
- *Сүхбаатар, Ховд аймаг төсвийн тодотголоор хүү, торгуулийн орлогыг нэмэгдүүлсэн байна.*

1.10. Дараах аймгуудын ИТХ-аас хүү, торгуулийн орлогыг 5.0-75.0 хувиар бууруулан баталсан байна. Тухайлбал:

*2023 он:*

- *Орхон аймаг 4,467.50 сая төгрөг буюу 75.0 хувь;*
- *Сүхбаатар аймаг 1,837.30 сая төгрөг буюу 75.0 хувь;*
- *Баян-Өлгий аймаг  861.16 сая төгрөг буюу 60.0 хувь;*
- *Хөвсгөл аймаг 1,637.70 сая төгрөг буюу 57.0 хувь;*
- *Сэлэнгэ аймаг 750.00 сая төгрөг буюу 50.0 хувь;*
- *Төв аймаг 852.63 сая төгрөг буюу 40.0 хувь;*
- *Хэнтий аймаг 945.99 сая төгрөг буюу 31.0 хувь;*

*2024 он:*

- *Булган аймаг 930.27 сая төгрөг буюу 58.0 хувь;*
- *Өвөрхангай аймаг 1,229.03 төгрөг буюу 47.0 хувь;*
- *Хөвсгөл аймаг 699.95 сая төгрөг буюу 44.0 хувь;*
- *Өмнөговь аймаг 1,298.21 сая төгрөг буюу 38.0 хувь;*
- *Төв аймаг 729.47 сая төгрөг буюу 36.0 хувь;*
- *Дорноговь аймаг 449.99 сая төгрөг 29.0 хувь;*
- *Баян-Өлгий аймаг 312.65 сая төгрөг 19.0 хувиар хувиар тус тус бууруулан баталсан.*

1.11. Хүү, торгуулийн орлогыг бууруулан баталсан нь дараах шалтгаантай байна. Тухайлбал:

- *Баян-Өлгий, Сүхбаатар, Орхон, Хэнтий аймаг өмнөх онуудын хүү, торгуулийн орлогын төлөвлөгөө тасарсан, тухайн жилийн хүлээгдэж буй гүйцэтгэлээр орлого бүрэн төвлөрөхгүй байх нөхцөл үүссэн, орлого бүрдүүлэгч байгууллагууд нь төлөвлөлт хийгээгүй, нэгдсэн судалгаа мэдээлэлгүй байсан зэрэгтэй холбоотой байна.*

1.12. Аудитын судалгаанаас харахад аймаг, нийслэлийн ИТХ-аас хүү, торгуулийн орлогыг батлахдаа өмнөх оны гүйцэтгэлийг 3.4-233.6 хувиар нэмэгдүүлсэн, 7.4-66.7 хувиар бууруулсан байна.

**Хүснэгт 3. Хүү, торгуулийн орлогын төлөвлөлт, төвлөрүүлэлт** (сая.төг)

| № | Аймаг, нийслэл | 2023 он | | | | 2024 он | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | Өмнөх оны гүйцэтгэл | ИТХ-ын батлсан дүн | Тухайн жилийн гүйцэтгэл | Өсөлт/ бууралт хувь | Өмнөх оны гүйцэтгэл | ИТХ-ын батлсан дүн | Тухайн жилийн гүйцэтгэл | Өсөлт/ бууралт хувь |
| 1 | Архангай | 1,232.00 | 2,845.91 | 505.17 | 131.0 | 505.17 | 1,685.07 | 403.88 | 233.6 |
| 2 | Баян-Өлгий | 848.30 | 584.14 | 1,210.65 | -31.1 | 1,210.65 | 1,300.96 | 1,296.41 | 7.5 |
| 3 | Баянхонгор | 1,937.90 | 2,120.68 | 1,568.71 | 9.4 | 1,568.71 | 1,330.08 | 1,070.25 | -15.2 |
| 4 | Булган | 1,137.50 | 2,540.24 | 1,760.35 | 123.3 | 1,760.35 | 665.43 | 1,297.07 | -62.2 |
| 5 | Говь-Алтай | 1,521.00 | 3,600.32 | 1,127.49 | 136.7 | 1,127.49 | 1,704.24 | 1,081.18 | 51.2 |
| 6 | Говь-сүмбэр | 870.10 | 900.00 | 673.17 | 3.4 | 673.17 | 1,362.20 | 1,013.70 | 102.4 |
| 7 | Дархан-Уул | 2,493.10 | 1,600.00 | 2,927.14 | -35.8 | 2,927.14 | 1,500.00 | 2,816.26 | -48.8 |
| 8 | Дорноговь | 1,127.30 | 2,285.71 | 3,389.11 | 102.8 | 3,389.11 | 1,127.71 | 4,868.92 | -66.7 |
| 9 | Дорнод | 1,921.70 | 2,868.59 | 1,091.50 | 49.3 | 1,091.50 | 1,356.75 | 2,123.65 | 24.3 |
| 10 | Дундговь | 1,401.40 | 2,928.00 | 9,770.95 | 108.9 | 9,770.95 | 12,128.99 | 1,198.09 | 24.1 |
| 11 | Өвөрхангай | 1,752.00 | 3,188.85 | 1,864.73 | 82.0 | 1,864.73 | 1,390.87 | 1,723.33 | -25.4 |
| 12 | Өмнөговь | 5,110.90 | 3,073.24 | 5,297.51 | -39.9 | 5,297.51 | 2,135.49 | 20,329.46 | -59.7 |
| 13 | Завхан | 2,022.00 | 1,009.13 | 760.83 | -50.1 | 760.83 | 834.60 | 910.22 | 9.7 |
| 14 | Орхон | 1,690.00 | 1,450.00 | 2,389.58 | -14.2 | 2,389.58 | 4,806.82 | 2,062.29 | 101.2 |
| 15 | Сүхбаатар | 907.30 | 600.00 | 1,175.20 | -33.9 | 1,175.20 | 2,585.36 | 999.63 | 120.0 |
| 16 | Сэлэнгэ | 1,915.00 | 750.00 | 2,222.35 | -60.8 | 2,222.35 | 1,750.00 | 2,238.17 | -21.3 |
| 17 | Төв | 2,588.90 | 1,293.57 | 2,951.98 | -50.0 | 2,951.98 | 1,291.03 | 3,779.27 | -56.3 |
| 18 | Увс | 1,480.90 | 1,531.91 | 1,128.20 | 3.4 | 1,128.20 | 1,050.00 | 1,664.08 | -6.9 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 19 | Хөвсгөл | 1,453.70 | 1,236.80 | 1,603.29 | -14.9 | 1,603.29 | 885.45 | 1,301.78 | -44.8 |
| 20 | Ховд | 1,202.10 | 1,113.62 | 1,293.27 | -7.4 | 1,293.27 | 1,900.70 | 1,230.62 | 47.0 |
| 21 | Хэнтий | 1,455.80 | 2,111.91 | 1,250.90 | 45.1 | 1,250.90 | 1,761.26 | 1,095.96 | 40.8 |
| 22 | Нийслэл | 82,613.70 | 113,103.92 | 108,121.90 | 36.9 | 108,121.90 | 179,516.00 | 142,507.02 | 66.0 |
| | **Нийт** | **118,682.60** | **152,736.54** | **154,083.98** | **28.7** | **154,083.98** | **224,069.01** | **197,011.24** | **45.4** |

Эх сурвалж: Аймаг, нийслэлийн нэгдсэн төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

1.13. Аймаг, нийслэлийн хэмжээнд хүү торгуулийн орлогын төлөвлөгөөг өмнөх оны гүйцэтгэлээс нэмэгдүүлсэн нь төлөгдөөгүй торгуулийг нөхөн төлүүлэх, тухайн оны татварын хяналт шалгалтын төлөвлөгөөнд орон нутагт үйл ажиллагаа явуулдаг томоохон ААНБ-ыг хамруулах, төсвийн тодотголоор тухайн жилийн орлогын гүйцэтгэлийг нэмэгдүүлж баталсан зэрэг шалтгаантай бол бууруулсан нь тухайн жилийн хүлээгдэж буй гүйцэтгэлээр орлого бүрэн төвлөрөхгүй байх нөхцөл үүссэнтэй холбоотой байна.

1.14. Хүү, торгуулийн орлого өмнөх оны төлөвлөгөөнөөс давсан болон тасарсныг үнэлж дүгнээгүй, орлогыг төлөвлөхдөө орлого бүрдүүлэгч байгууллагуудын зөрчлийн тоо хэмжээ, хэрэгжилт зэрэг суурь судалгаагүй, дүн шинжилгээ хийгээгүй нь холбогдох хууль, журам, зааварт үнэлж дүгнэх талаар тусгаагүйтэй холбоотой байна.

***Хүү, торгуультай холбоотой харилцааг зохицуулж байгаа зарим хууль, эрх зүйн актын уялдаа, нийцлийг хангуулж шинэчлэн сайжруулах шаардлага байна.***

1.15. Хүү, торгуулийн орлого нь төсвийн тогтвортой эх үүсвэр, төсөв бүрдүүлэхээс илүүтэй хуульд нийцүүлэн гаргасан захиргааны хэм хэмжээний актыг зөрчсөн үйлдэлд хариуцлага тооцох, зөрчил үйлдсэн хүн, хуулийн этгээдэд шийтгэл оногдуулах замаар шударга ёсны тогтолцоог бэхжүүлэх зорилготой байна.

1.16. Төсвийн тухай, Зөрчлийн тухай, Зөрчил шалган шийдвэрлэх тухай, Татварын тухай, Нийгмийн даатгалын тухай, Гаалийн тухай, Авто замын тухай, Банк, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, мөнгөн хөрөнгийн шилжүүлэг, зээлийн үйл ажиллагааны тухай хууль болон холбогдох 230 гаруй хууль, дүрэм, журмаар хүү, торгуультай холбоотой харилцаа зохицуулагдаж байна.

1.17. Зөрчлийн тухай хуулийн 1.3 дугаар зүйлийн 1[5] дэх хэсэгт зөрчил үйлдсэн этгээдэд оногдуулах шийтгэл нь шударга ёсны зарчимд нийцсэн, үйлдсэн зөрчилтэй тохирсон байхаар хуульчилсан нь торгууль хэт өндөр, эсвэл хэт бага байж болохгүй гэсэн ерөнхий зарчмыг агуулж байгаа хэдий ч харилцан адилгүй заалтууд байна. Тухайлбал:

- *Зөрчлийн тухай хуулийн 11.19 дүгээр зүйлийн 8.1[6] дэх хэсэгт заасны дагуу төлбөрийн баримт олгоогүй тохиолдолд хуулийн этгээдийг өмнөх сарын борлуулалтын орлогын 2 хувиар, 8.2 дахь хэсэгт төлбөрийн баримтыг борлуулалтын үнийн дүнгээс зөрүүтэй олгосон зөрчилд өмнөх сарын борлуулалтын орлогын 20 хувиар торгох зохицуулалттай байна. Дээрх 2 зөрчлийг харьцуулахад төлбөрийн баримт огт олгоогүй зөрчил нь хариуцлага алдсан магадлал өндөр байхад торгуулийн хувь хэмжээ өөр;*
- *Зөрчлийн тухай хуулийн 14.7[7] дугаар зүйлийн 20 дахь хэсэг "Замын хөдөлгөөний дүрэмд зааснаар тээврийн хэрэгслийн жолооч, эсхүл зорчигч хамгаалах бүс*

[5] 1.Зөрчил үйлдсэн хүн, хуулийн этгээдэд оногдуулах шийтгэл, албадлагын арга хэмжээний төрөл, хэмжээ нь зөрчил үйлдэгдсэн нөхцөл байдал, зөрчлийн шинж, хохирлын хэр хэмжээнд тохирсон байна.
[6] төлбөрийн баримт олгоогүй бол өмнөх тайлант сарын хугацаанд олсон орлогын үнийн дүнгийн 2 хувь
[7] Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль зөрчих

*хэрэглээгүй бол хүнийг хорин нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно", 21 дэх хэсэг "Мотоцикл, мопедын жолооч, эсхүл зорчигч хамгаалалтын малгай өмсөөгүй бол хүнийг арван нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно" гэж заасан нь аюулын түвшин ижил байхад торгуулийн хувь хэмжээ өөр байна.*

1.18. Зөрчлийн тухай хуулийн 11.19 дүгээр зүйлд татварын хууль зөрчихөд хүлээлгэх хариуцлагыг хуульчилсан ч Татварын ерөнхий хуулийн 82-84 дүгээр зүйлд хууль тогтоомж зөрчсөн этгээдэд хүлээлгэх хариуцлагын талаар тусгасан байна.

1.19. Зөрчлийн тухай хуульд 2023 онд 13 удаа, 2024 онд 16 удаа нэмэлт, өөрчлөлт оржээ. Эдгээр нэмэлт өөрчлөлтөөр торгуулийг хугацаанд нь төлсөн иргэн, хуулийн этгээдийн торгуулийг 50 хувиар хөнгөлөх зохицуулалт бий болсон нь иргэн, хуулийн этгээд хугацаандаа торгуулиа төлөхөд эергээр нөлөөлж байна.

***Торгууль оногдуулах эрх бүхий албан тушаалтнаас оногдуулсан зарим шийдвэр хууль тогтоомжид нийцээгүйгээс өөрчлөгдөх, хүчингүй болох тохиолдол гарч байна.***

1.20. УЕПГ-аас ирүүлсэн судалгаагаар зөрчил шалган шийдвэрлэх эрх бүхий 9542 улсын байцаагчийн эрхтэй албан тушаалтан 65 салбарт харьяаллын дагуу зөрчлийг шалган шийдвэрлэж байна. Нутаг дэвсгэрийн хувьд нийслэл Улаанбаатар хотод 4190 буюу 43.9 хувь, аймаг, орон нутагт 5352 буюу 56.1 хувь нь харьяалагдаж байна.

1.21. Дээрх ЭБАТ-аас 2023 онд 3155433 зөрчил, 2024 онд 3274196 зөрчил, нийт 6429629 зөрчилд шийтгэл оногдуулсан байна.

**Хүснэгт 4. Эрх бүхий албан тушаалтны шийтгэл оногдуулсан байдал**

| Он | Шийдвэрийн төрөл | | | Бүртгэгдсэн зөрчлийн дүн |
|---|---|---|---|---|
| | Хялбаршуулсан журмаар шийтгэл оногдуулсан | Газар дээр нь шийтгэл оногдуулсан | Ердийн журмаар шийтгэл оногдуулсан | |
| 2023 | 123448 | 3025909 | 6076 | 3155433 |
| 2024 | 129069 | 3137819 | 7308 | 327496 |
| **Нийт** | **252517** | **6163728** | **13384** | **6429629** |

Эх сурвалж: Улсын Ерөнхий Прокурорын газрын судалгаа

1.22. Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 2.2 дугаар зүйлийн 1[8] дэх хэсэгт заасны дагуу УЕПГ-аас дээрх зөрчлийн хэрэг бүртгэлд хяналт хэрэгжүүлж *"хуульд заасан үндэслэлийг буруу хэрэглэсэн", "нотлох баримт дутуу бүрдүүлсэн"* зэрэг шалтгаанаар 2023 онд 47519, 2024 онд 8234, нийт 55753 зөрчлийг хүчингүй болгох, өөрчлөх дүгнэлтийг гаргасан байна.

**Дүрслэл 1.УЕПГ-аас ЭБАТ-ны шийдвэрийг хүчингүй болгосон, өөрчлөлт оруулахаар дүгнэлт гаргасан байдал**




Хүчингүй болгох, өөрчлөх дүгнэлт гаргасан зөрчлийн тоо 2023 онд нийт зөрчлийн 1.4 хувь байсан бол 2024 онд 0.2 хувь болж буурчээ.

[8] Прокурор зөрчлийн хэрэг бүртгэлтэд хяналт тавих дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ, зөрчлийн хэрэг бүртгэлт хуулийн хүрээнд явагдаж байгаа эсэхийг хянах

# БҮЛЭГ 2. ХҮҮ,ТОРГУУЛИЙН ОРЛОГЫГ ОРОН НУТГИЙН ТӨСӨВТ ТӨВЛӨРҮҮЛЭХ ТӨСВИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТ ХАНГАЛТГҮЙ БАЙНА.

2.1. Хүү, торгуулийн эх үүсвэрээс 2023, 2024 онуудад нийт 361,173.77 сая төгрөгийн орлого төвлөрсөн байна.

**Хүснэгт 5. Хүү, торгуулийн орлогын бүрдүүлэлт** (сая.төг)

| № | Аймаг, нийслэл | Хүүгийн гүйцэтгэл | | Торгуулийн гүйцэтгэл | | Нийт | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | 2023 он | 2024 он | 2023 он | 2024 он | 2023 он | 2024 он | Дүн |
| 1 | Архангай | 111.90 | 57.10 | 393.27 | 346.78 | 505.17 | 403.88 | 909.05 |
| 2 | Баян-Өлгий | 52.14 | 63.27 | 1,158.51 | 1,233.14 | 1,210.65 | 1,296.41 | 2,507.06 |
| 3 | Баянхонгор | 145.25 | 159.46 | 1,423.46 | 910.79 | 1,568.71 | 1,070.25 | 2,638.96 |
| 4 | Булган | 43.16 | 79.00 | 1,717.19 | 1,218.07 | 1,760.35 | 1,297.07 | 3,057.42 |
| 5 | Говь-Алтай | 25.78 | 32.06 | 1,101.71 | 1,049.12 | 1,127.49 | 1,081.18 | 2,208.67 |
| 6 | Говьсүмбэр | 48.50 | 23.30 | 624.67 | 990.40 | 673.17 | 1,013.70 | 1,686.87 |
| 7 | Дархан-Уул | - | 2.85 | 2,927.14 | 2,813.41 | 2,927.14 | 2,816.26 | 5,743.40 |
| 8 | Дорноговь | 97.70 | 440.60 | 3,291.41 | 4,428.32 | 3,389.11 | 4,868.92 | 8,258.03 |
| 9 | Дорнод | - | - | 1,091.50 | 2,123.65 | 1,091.50 | 2,123.65 | 3,215.15 |
| 10 | Дундговь | 70.80 | 64.70 | 9,700.25 | 1,133.39 | 9,770.95 | 1,198.09 | 10,969.04 |
| 11 | Өвөрхангай | 66.10 | 75.80 | 1,798.63 | 1,647.53 | 1,864.73 | 1,723.33 | 3,588.06 |
| 12 | Өмнөговь | 433.86 | 510.40 | 4,863.65 | 19,819.06 | 5,297.51 | 20,329.46 | 25,626.97 |
| 13 | Завхан | - | - | 760.83 | 910.22 | 760.83 | 910.22 | 1,671.05 |
| 14 | Орхон | 143.10 | 0.80 | 2,246.48 | 2,061.49 | 2,389.58 | 2,062.29 | 4,451.87 |
| 15 | Сүхбаатар | 49.50 | 54.83 | 1,125.70 | 944.80 | 1,175.20 | 999.63 | 2,174.83 |
| 16 | Сэлэнгэ | - | - | 2,222.35 | 2,238.17 | 2,222.35 | 2,238.17 | 4,460.52 |
| 17 | Төв | 224.40 | 20.50 | 2,727.58 | 3,758.77 | 2,951.98 | 3,779.27 | 6,731.25 |
| 18 | Увс | 67.90 | 133.76 | 1,060.30 | 1,530.32 | 1,128.20 | 1,664.08 | 2,792.28 |
| 19 | Хөвсгөл | 203.83 | 276.81 | 1,399.46 | 1,024.97 | 1,603.29 | 1,301.78 | 2,905.07 |
| 20 | Ховд | 187.41 | 146.09 | 1,105.86 | 1,084.53 | 1,293.27 | 1,230.62 | 2,523.89 |
| 21 | Хэнтий | 51.03 | 62.34 | 1,199.87 | 1,033.62 | 1,250.90 | 1,095.96 | 2,346.86 |
| 22 | Нийслэл | - | 20,942.47 | 108,121.90 | 121,564.55 | 108,121.90 | 142,507.02 | 250,628.92 |
| 23 | Улсын төсөв | - | - | 5,774.13 | 4,304.42 | 5,774.13 | 4,304.42 | 10,078.55 |
| | **Нийт** | **2,022.36** | **23,146.14** | **157,835.75** | **178,169.52** | **159,858.11** | **201,315.66** | **361,173.77** |

Эх сурвалж: Аудитын судалгаа

***Торгуулийн орлогын талаар: (Орон нутгийн төсөвт төвлөрсөн орлого)***

2.2. 2023, 2024 онуудад нийт 322,676.35 сая төгрөгийн торгууль ногдуулж, орон нутгийн төсөвт 325,926.72 сая төгрөг төвлөрч, биелэлт 101.0 хувьтай байгаа нь өмнөх оны биелэгдээгүй үлдэгдэл, дараа онд төвлөрч байгаатай холбоотой байна.

2.3. 2023 онд 122,450.45 сая төгрөгийн торгууль ногдуулж, 152,061.60 сая төгрөг буюу 124.2 хувь, 2024 онд 193,328.78 сая төгрөгийн торгууль ногдуулж, 173,865.12 сая төгрөг буюу 89.9 хувийн биелэлттэй байна.

**Хүснэгт 6. Торгуулийн ногдуулалт, бүрдүүлэлт** (сая.төг)

| № | Аймаг, нийслэл | 2023 он | | | 2024 он | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | Ногдуулсан | Төвлөрүүлсэн | Дутуу хувиар | Ногдуулсан | Төвлөрүүлсэн | Дутуу хувиар |
| 1 | Архангай | 411.96 | 393.27 | -4.5 | 405.38 | 346.78 | -14.5 |
| 2 | Баян-Өлгий | 1,362.24 | 1,158.51 | -15.0 | 1,588.28 | 1,233.14 | -22.4 |
| 3 | Баянхонгор | 1,595.97 | 1,423.46 | -10.8 | 1,205.77 | 910.79 | -24.5 |
| 4 | Булган | 2,002.20 | 1,717.19 | -14.2 | 1,750.93 | 1,218.07 | -30.4 |
| 5 | Говь-Алтай | 1,214.48 | 1,101.71 | -9.3 | 1,250.96 | 1,049.12 | -16.1 |
| 6 | Говьсүмбэр | 704.40 | 624.67 | -11.3 | 1,151.10 | 990.40 | -14.0 |
| 7 | Дархан-Уул | 3,419.90 | 2,927.14 | -14.4 | 3,192.92 | 2,813.41 | -11.9 |
| 8 | Дорноговь | 3,400.58 | 3,291.41 | -3.2 | 4,696.15 | 4,428.32 | -5.7 |
| 9 | Дорнод | 2,020.85 | 1,091.50 | -46.0 | 3,188.05 | 2,123.65 | -33.4 |
| 10 | Дундговь | 9,716.82 | 9,700.15 | -0.2 | 1,179.53 | 1,133.39 | -3.9 |
| 11 | Завхан | 925.85 | 760.83 | -17.8 | 1,128.87 | 910.22 | -19.4 |
| 12 | Орхон | 2,438.55 | 2,246.48 | -7.9 | 2,717.29 | 2,061.49 | -24.1 |
| 13 | Өвөрхангай | 1,986.72 | 1,798.63 | -9.5 | 1,889.18 | 1,647.53 | -12.8 |
| 14 | Өмнөговь | 7,379.64 | 4,863.65 | -34.1 | 22,228.03 | 19,819.06 | -10.8 |
| 15 | Сүхбаатар | 1,263.90 | 1,125.70 | -10.9 | 1,173.50 | 944.80 | -19.5 |
| 16 | Сэлэнгэ | 2,541.40 | 2,222.35 | -12.6 | 2,642.02 | 2,238.17 | -15.3 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 17 | Төв | 2,916.32 | 2,727.58 | -6.5 | 3,711.02 | 3,758.77 | 1.3 |
| 18 | Увс | 1,263.51 | 1,060.30 | -16.1 | 1,489.54 | 1,530.32 | 2.7 |
| 19 | Ховд | 1,249.90 | 1,105.86 | -11.5 | 1,079.95 | 1,084.53 | 0.4 |
| 20 | Хөвсгөл | 1,610.28 | 1,399.46 | -13.1 | 1,249.90 | 1,024.97 | -18.0 |
| 21 | Хэнтий | 1,446.61 | 1,199.87 | -17.1 | 1,494.94 | 1,033.62 | -30.9 |
| 22 | Нийслэл | 71,578.36 | 108,121.88 | 43.5 | 132,915.45 | 121,564.57 | -10.7 |
| | **Нийт** | **122,450.45** | **152,061.60** | **20.5** | **193,328.78** | **173,865.12** | **-11.5** |

Эх сурвалж: Аудитын судалгаа

2.4. Аймгуудын хэмжээнд тухайн жилд ногдуулсан торгуулийн орлого төвлөрүүлсэн дүнг авч үзвэл 2023 онд 0.2-46.0 хувь, 2024 онд 3.9-33.4 хувиар тус тус дутуу төвлөрсөн байна.

**Дүрслэл 2. Аймгуудаас ногдуулсан торгуулийн орлогын биелэлт**

2023 он
Ногдуулсан: 50,872.09 сая төгрөг,
Төвлөрүүлсэн: 0.2-46.0 хувиар дутуу буюу нийт 43,939.72 сая төгрөг

2024 он
Ногдуулсан: 60,413.33 сая төгрөг,
Төвлөрүүлсэн: 3.9-33.4 хувиар дутуу буюу нийт 52,300.55 сая төгрөг

2.5. Ногдуулсан орлогыг дутуу төвлөрүүлсэн нь дараах шалтгаантай байна. Тухайлбал;

- ➢ *Архангай, Баян-Өлгий, Баянхонгор, Булган, Говь-Алтай, Говьсүмбэр, Дархан-Уул, Дорноговь, Дорнод, Дундговь, Завхан, Орхон, Өвөрхангай, Өмнөговь, Сүхбаатар, Сэлэнгэ, Хөвсгөл, Хэнтий аймгууд 16.67-2,515.99 сая төгрөгөөр дутуу төвлөрүүлсэн нь цагдаагийн байгууллагаас ногдуулсан торгууль тухайн ондоо бүрэн төвлөрөөгүйтэй холбоотой байна.*

2.6. Нийслэл болон зарим аймгууд ногдуулсан орлогын төлөвлөгөөг бүрэн биелүүлсэн байна. Үүнд:

- ➢ *Нийслэл 2023, 2024 онд 211,390.93 сая төгрөгийн торгууль ногдуулж, 229,686.45 сая төгрөг буюу 108.7 хувь;*
- ➢ *Ховд аймаг 2024 онд 1,079.95 сая төгрөгийн торгууль ногдуулж, 1,084.53 сая төгрөг буюу 100.4 хувь;*
- ➢ *Төв аймаг 3,711.02 сая төгрөгийн торгууль ногдуулж, 3,758.77 сая төгрөг буюу 101.3 хувь;*
- ➢ *Увс аймаг 1,489.54 сая төгрөгийн торгууль ногдуулж, 1,530.32 сая төгрөг буюу 102.7 хувиар тус тус биелүүлсэн байна.*

***Улсын төсөвт төвлөрсөн торгуулийн орлого:***

2.7.Аудитын түүвэрт дараах байгууллагуудыг хамруулахад улсын төсөвт 10,078.54 сая төгрөгийн орлого төвлөрүүлсэн байна.

**Хүснэгт 7. Торгуулийн орлого бүрдүүлэлт** (сая.төг)

| № | Байгууллага | 2023 он | | 2024 он | | НИЙТ | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | Нийт ногдуулсан | Улсын төсөвт | Нийт ногдуулсан | Улсын төсөвт | Нийт ногдуулсан | Улсын төсөвт |
| 1 | ГЕГ | 5,162.55 | 5,130.38 | 3,899.13 | 3,719.58 | 9,061.68 | 8,849.95 |
| 2 | УБЕГ | 81.52 | 81.52 | - | - | 81.52 | 81.52 |
| 3 | ЭМДЕГ | - | - | - | 31.00 | - | 31.00 |
| 4 | ЭЭХХЗГ | - | 35.55 | - | 130.95 | - | 166.50 |
| 5 | ЗТЯ | 345.70 | 343.00 | 313.41 | 148.39 | 659.11 | 491.39 |
| 6 | ГЗБГЗЗЕГ | 515.99 | 102.69 | 902.20 | 188.50 | 1,418.19 | 291.19 |
| 7 | БОУАӨЯ | 81.00 | 81.00 | 86.00 | 86.00 | 167.00 | 167.00 |
| | **Нийт** | **6,186.75** | **5,774.13** | **5,200.74** | **4,304.42** | **11,387.49** | **10,078.54** |

Эх сурвалж: Аудитын судалгаа

**Дүрслэл 3. Торгуулийн орлого бүрдүүлэлт (байгууллагаар)**




2.8. Торгуулийн орлого бүрдүүлсэн байдлыг байгууллагаар нь авч үзвэл 59.8 хувийг татварын байгууллага, 35.4 хувийг цагдаагийн байгууллага, 3.4 хувийг гаалийн байгууллага, 1.3 хувийг бусад газраас төвлөрүүлсэн байна.

2.9. Төсвийн тухай хуулиар хүү, торгуулийн орлого нь орон нутгийн төсөвт төвлөрөх зохицуулалтай ч зарим байгууллагаас оногдуулсан торгуулийн орлого улсын төсөв болон тухайн байгууллагын төсөвт төвлөрч хуулийн хэрэгжилт хангагдаагүй байна.

2.10. Аудитын судалгаанаас харахад улс, орон нутгийн хэмжээнд нийт 205 дансанд хүү, торгуулийн орлого төвлөрч, үүнээс 144 данс аймаг, нийслэл, сум, дүүрэгт, 48 данс улсын төсвийн байгууллагуудад, 13 данс СЯ-нд хамаарч байна.

2.11. Торгуулийн орлого төвлөрч буй дээрх данснуудыг ангилсан ч дансанд төвлөрч байгаа зарим орлого нь ямар байгууллагаас ногдуулсан нь тодорхойгүй, нэхэмжлэлийн дугаараар төлөгдсөн нь орлогын төлөвлөгөөний биелэлтийг байгууллага бүрээр гаргах боломжгүй байна.

2.12. СЯ-ны хүү, торгуулийн орлого төвлөрч буй улсын төсвийн 13 дансны хуулгыг шалгахад тус дансанд хүү, торгуулийн орлогоос гадна татварын торгууль, алданги, хяналт шалгалтын орлого, аудитын төлбөрийн актын орлого, Монополын эсрэг газар, Монгол банк, Хадгаламжийн даатгалын корпорац зэрэг байгууллагуудын хяналт шалгалтын орлого байна.

***Хүүгийн орлогын талаар:***

2.13. Хүүгийн орлогын эх үүсвэр нь Засгийн газрын гадаад зээлийн хөрөнгийг дотоодод дамжуулан зээлдүүлэх зээлийн гэрээнд заасан хуваарийн дагуу төсөвт тусгасан хүүгийн төлбөрөөс бүрдэж байна.

2.14. Хүүгийн орлогыг 2023 онд 58,889.56 сая төгрөгөөр төлөвлөж, гүйцэтгэлээр 2,022.36 сая төгрөг буюу 3.0 хувь, 2024 онд 56,354.19 сая төгрөгөөр төлөвлөж, гүйцэтгэлээр 23,146.14 сая төгрөг буюу 41.0 хувийг орон нутгийн төсөвт тус тус төвлөрүүлсэн байна.

**Хүснэгт 8. Хүүгийн орлого бүрдүүлэлт** (сая.төг)

| № | Аймаг, нийслэл | 2023 он | | | 2024 он | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | Төлөвлөсөн | Төвлөрүүлсэн | Хувь | Төлөвлөсөн | Төвлөрүүлсэн | Хувь |
| 1 | Архангай | 1,945.91 | 111.90 | 5.8 | 508.67 | 57.10 | 11.2 |
| 2 | Баян-Өлгий | 371.14 | 52.14 | 14.0 | 113.60 | 63.27 | 55.7 |
| 3 | Баянхонгор | 750.68 | 145.25 | 19.3 | 47.58 | 159.46 | 335.2 |
| 4 | Булган | 2,389.04 | 43.16 | 1.8 | 595.69 | 79.00 | 13.3 |
| 5 | Говь-Алтай | 779.78 | 25.78 | 3.3 | 418.24 | 32.06 | 7.7 |
| 6 | Говьсүмбэр | - | 48.50 | - | - | 23.30 | - |
| 7 | Дархан-Уул | - | - | - | - | 2.85 | - |
| 8 | Дорноговь | 550.00 | 97.70 | 17.8 | 577.71 | 440.60 | 76.3 |
| 9 | Дорнод | 1,736.59 | - | - | 224.75 | - | - |
| 10 | Дундговь | 2,540.40 | 70.80 | 2.8 | 628.99 | 64.70 | 10.3 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 11 | Өвөрхангай | 2,976.85 | 66.10 | 2.2 | 1,069.87 | 75.80 | 7.1 |
| 12 | Өмнөговь | 1,036.62 | 433.86 | 41.9 | 1,076.79 | 510.40 | 47.4 |
| 13 | Завхан | 98.93 | - | - | 683.60 | - | - |
| 14 | Орхон | - | 143.10 | - | 2,956.82 | 0.80 | - |
| 15 | Сүхбаатар | - | 49.50 | - | 345.36 | 54.83 | 15.9 |
| 16 | Сэлэнгэ | - | - | - | - | - | - |
| 17 | Төв | 346.17 | 224.40 | 64.8 | 20.51 | 20.50 | 99.9 |
| 18 | Увс | 681.91 | 67.90 | 10.0 | - | 133.76 | - |
| 19 | Хөвсгөл | 836.80 | 203.83 | 24.4 | 485.45 | 276.81 | 57.0 |
| 20 | Ховд | 323.18 | 187.41 | 58.0 | - | 146.09 | - |
| 21 | Хэнтий | - | 51.03 | - | - | 62.34 | - |
| 22 | Нийслэл | 41,525.56 | - | - | 46,600.55 | 20,942.47 | 44.9 |
| | **Нийт** | **58,889.56** | **2,022.36** | **3.4** | **56,354.19** | **23,146.14** | **41.1** |

Эх сурвалж: Аймаг, нийслэлийн ИТХ-ын тогтоол, аудитын судалгаа

2.15. Хүүгийн орлогын төлөвлөгөөг 59.0-97.0 хувиар дутуу төвлөрүүлсэн нь зээлийн гэрээнд заасан хүүгийн хувь хэмжээг үндэслэн эргэн төлөлтийн хуваарийг төлөвлөж байгаатай холбоотой байна.

***Нийгмийн даатгалын чөлөөт үлдэгдлийн хүү:***

2.16. Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 12 дугаар зүйлийн 12.3[9] дахь хэсэгт заасны дагуу 2023, 2024 онуудад нийт 42,092.90 сая төгрөгийн хүүгийн орлого төлөвлөж, 43,888.90 сая төгрөгийг төвлөрүүлсэн байна.

**Дүрслэл 4. НД-ын хүүгийн орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл**




2.17. Төсвийн тухай хуулийн 8.5 дугаар зүйлийн 8.5.1[10], 8.5.2[11], Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.9[12]-д заасны дагуу аймаг, нийслэлийн Засаг дарга тухайн жилийн төсвийн төслийг боловсруулан, ИТХ-аар хэлэлцүүлэн батлуулах эрх зүйн зохицуулалтай байна.

2.18. Хүү, торгуулиас бүрдсэн орлогыг төсөвт дараах байдлаар хуваарилахаар тусгажээ. Үүнд:

- ✓ *Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1-д заасны дагуу "Зөрчлийн тухай хуулийн холбогдох зүйл хэсэгт заасан зөрчилд оногдуулсан торгох шийтгэлийг биелүүлж, төсөвт төвлөрүүлсэн мөнгөн дүнгийн 20-иос доошгүй хувьтай тэнцэх хэмжээний хөрөнгийг дүрс бичлэгийн техник, хэрэгсэл, зөрчил болон эрүүгийн хэрэг хянан шалгах байгууллагын мэдээллийн нэгдсэн системийг сайжруулах ажилд, 20-иос*

---

[9]Аймаг, дүүргийн нийгмийн даатгалын байгууллага нь нийгмийн даатгалын сан тус бүрийн орлогын зарцуулагдаагүй үлдэгдлийг нийгмийн даатгалын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын холбогдох дансанд сар бүр төвлөрүүлнэ

[10]аймаг, нийслэлийн Засаг дарга, улсын зэрэглэлтэй хотын Захирагч тухайн шатны жилийн төсвийн төслийг жил бүрийн 11 дүгээр сарын 20-ны дотор төрийн аудитын байгууллагад хүргүүлж, 11 дүгээр сарын 25-ны дотор тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурал болон Зөвлөлд өргөн мэдүүлэх;

[11]аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, улсын зэрэглэлтэй хотын Зөвлөл тухайн шатны жилийн төсвийн төслийг хэлэлцэн жил бүрийн 12 дугаар сарын 05-ны дотор батлах;

[12]Засаг даргын өргөн мэдүүлснээр тухайн аймаг, сум, нийслэл, дүүргийн төсвийг хэлэлцэж батлах, түүнд нэмэлт, өөрчлөлт оруулах, гүйцэтгэлийг батлах;

*доошгүй хувьтай тэнцэх хэмжээний хөрөнгийг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх бусад ажилд зориулан дараагийн жилийн төсөвт тусгах";*

- ✓ *Авто замын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.2.4 дэх заалт, МУЗГ-ын 2019 оны 312 дугаар тушаалаар баталсан "Авто замын санд хөрөнгө төвлөрүүлэх захиран зарцуулах журам"-ын 2.5 дугаар хэсгийн 2.5.4-т нийслэл, орон нутгийн авто зам дээр гарсан зөрчилд ногдуулсан торгуулийг орон нутгийн авто замын сангийн тусгай дансанд төвлөрүүлж зарцуулахаар байна.*

2.19. Хүү, торгуулийн орлогын зарцуулалтыг аймаг, нийслэлийн хувьд төсвийн ерөнхийлөн захирагч, сум, дүүргийн хувьд төсвийн төвлөрүүлэн захирагч нар чиг үүргийн дагуу хуваарилж байна. **Хавсралт 2**

**Дүрслэл 5. Аймаг, нийслэл, дүүргийн ИТХ-ын төсөв баталсан тогтоолд хүү, торгуулийн орлогыг тусгасан байдал**




2.20. Аймаг, нийслэлийн хэмжээнд 2023, 2024 онд хүү, торгуулийн эх үүсвэрээс нийт 351,095.22 сая төгрөгийн орлого төвлөрснөөс гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажил болон авто замын санд 104,240.99 сая төгрөг буюу 29.69 хувийг, "Орон нутгийн төсвийн суурь орлого"-д 246,854.32 сая төгрөг буюу 70.31 хувийг зарцуулахаар хуваарилсан байна.

**Дүрслэл 6. Хүү, торгуулийн орлогын хуваарилалт**




***Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд төсөв хуваарилсан байдал:***

2.21. Орон нутгийн төсөв батлах, хуваарилах эрх бүхий байгууллагууд орон нутагт төвлөрүүлсэн хүү, торгуулийн орлогыг төсвийн орлогын нэр төрлөөр баталсан ч сумдын түвшинд харилцан адилгүй, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиг үүргийг хэрэгжүүлэх төсвийг тухайн жилийн төсөвт хуваарилаагүй байна.

**Хүснэгт 9. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын төсөвт баталсан санхүүжилт** (сая.төг)

| № | Аймаг, нийслэл | 2023 он | | | 2024 он | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | Торгууль ноогдуулсан дүн | Батлагдсан төсөв | Дундаж хувь | Торгууль ноогдуулсан дүн | Батлагдсан төсөв | Дундаж хувь |
| 1 | Аймаг | 43,931.50 | 5,320.10 | 12.1 | 52,284.60 | 7,349.50 | 14.0 |
| 2 | Нийслэл | 108,121.80 | 18,290.40 | 16.9 | 121,564.57 | 24,951.40 | 20.5 |
| | **Нийт** | **152,053.30** | **23,610.50** | **15.5** | **173,849.17** | **32,300.99** | **18.6** |

Эх сурвалж:Аудитын судалгаа

2.22. Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн дагуу хүү, торгуулийн орлогоос бүрдсэн хөрөнгийн 40-оос доошгүй хувийг гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан

сэргийлэх ажилд хуваарилж зарцуулах зохицуулалтай хэдий ч орон нутгийн хэмжээнд төвлөрсөн орлогоос дунджаар 17.0 хувийг хуваарилсан байна.

2.23. Дараах аймаг, сумууд хүү,торгуулийн орлогыг 11.3-63.3 хувиар дутуу хуваарилсан байна. **Хавсралт 3**

- *Булган аймгийн Бугат, Баян-Агт, Баяннуур, Бүрэгхангай, Дашинчилэн, Гурванбулаг, Могод, Сайхан, Хутаг-өндөр, Хишиг-өндөр, Тэшиг, Сэлэнгэ, Орхон, Хангал сумууд 29.9-42.5 хувиар;*
- *Говь-Алтай аймгийн Тонхил, Төгрөг, Жаргалан, Хөхморьт, Цээл, Шарга, Эрдэнэ, Есөнбулаг сумууд 39.4-56.0 хувиар;*
- *Дорноговь аймгийн Айраг, Замын-Үүд, Даланжаргалан, Дэлгэрэх, Эрдэнэ, Замын-Үүд сумууд 15.9-41.4 хувиар;*
- *Завхан аймгийн Асгат, Баянхайрхан, Тэлмэн, Эрдэнэхайрхан, Алдархаан, Цагаанхайрхан сумууд 11.3 хувиар;*
- *Өвөрхангай аймгийн Арвайхээр, Хайрхандулаан, Бүрд, Тарагт, Уянга, Төгрөг, Өлзийт, Сант, Нарийнтээл, Зүүнбаян-Улаан, Хужирт, Хархорин, Баруунбаян-Улаан сумууд 36.6-40.2 хувиар;*
- *Сүхбаатар аймгийн Асгат, Баяндэлгэр, Мөнххаан, Онгон, Түмэнцогт, Уулбаян, Халзан, Эрдэнэцагаан, Сүхбаатар, Баруун-Урт сумууд 13.7-21.0 хувиар;*
- *Сэлэнгэ аймгийн Шаамар, Цагааннуур, Хүдэр, Сүхбаатар, Сант, Сайхан, Орхон Мандал, Ерөө, Баянгол, Баруунбүрэн, Булган, Бугат, Баян-Агт, Баяннуур сумууд 56.6-63.3 хувиар тус тус дутуу хуваарилсан байна.*

2.24. Дараах аймаг, сумууд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд төсөв хуваарилаагүй байна. Үүнд:

- *Баян-Өлгий аймгийн Алтай, Алтанцөгц, Баяннуур, Бугат, Булган, Буянт, Дэлүүн сумууд;*
- *Завхан аймгийн Баянтэс, Дөрвөлжин, Завханмандал, Нөмрөг, Отгон, Түдэвтэй, Улиастай, Сантмаргац, Цэцэн-Уул, Шилүүстэй, Яруу сумууд;*
- *Төв аймгийн Өндөрширээт, Аргалант сумууд;*
- *Увс аймгийн Давст сум.*

2.25. Сумдын Засаг дарга нар гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд зориулсан хөрөнгийг гэмт хэрэг, хэв журмын зөрчлийн байдлыг харгалзан хуваарилаагүй нь гэмт хэргийн шалтгаан нөхцөлийг тогтоох, арилгах, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиг үүрэгт нөлөөлж болзошгүй байна.

***Автозамын санд төсөв хуваарилсан байдал:***

2.26. Авто замын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.2 дэх хэсэгт нийслэл, орон нутгийн авто зам дээр хөдөлгөөний аюулгүй байдлын зөрчил гаргасан, авто замын талаарх хууль тогтоомжийг зөрчсөн этгээдэд ногдуулсан торгуулийг автозамын санд төвлөрүүлэхээр заасан ч хуулийн хэрэгжилт хангалтгүй байна. Үүнд:

- *Баян-Өлгий, Булган, Говь-Алтай, Говьсүмбэр, Дорноговь, Дорнод, Дундговь, Завхан, Сүхбаатар, Сэлэнгэ, Төв, Увс Хөвсгөл, Хэнтий аймгууд замын сан төсөв хуваарилаагүй байна.*

2.27.Нийслэл, Архангай, Баянхонгор, Дархан-Уул, Орхон, Ховд, Өвөрхангай, Өмнөговь аймгууд нийт 48,329.50 сая төгрөгийг замын санд хуваарилсан байна.

**Хүснэгт 10. Хүү, торгуулийн орлогоос авто замын санд хуваарилсан санхүүжилт** (сая.төг)

| № | Аймаг, нийслэл | 2023 он | | 2024 он | |
|---|---|---|---|---|---|
| | | Торгуулийн дүн | Авто замын сан | Торгуулийн дүн | Авто замын сан |
| 1 | Нийслэл | 71,323.48 | 11,700.00 | 93,977.40 | 24,300.00 |
| 2 | Баянхонгор | 1,423.46 | 1,440.90 | 910.70 | 885.00 |
| 3 | Дархан-Уул | 2,927.14 | 1,692.60 | 2,813.41 | 71.00 |
| 4 | Орхон | 2,246.48 | 1,817.70 | 2,061.49 | 1,719.89 |
| 5 | Архангай | 393.27 | 1,104.93 | 346.78 | 2,502.61 |
| 6 | Ховд | 1,105.86 | 87.95 | 1,084.53 | 74.65 |
| 7 | Өвөрхангай | 1,798.63 | 240.60 | 1,647.53 | 158.74 |
| 8 | Өмнөговь | 4,863.65 | 264.86 | 19,819.06 | 267.81 |
| **Нийт** | | **86,082.00** | **18,349.70** | **122,661.00** | **29,979.80** |

Эх сурвалж: Аудитын судалгаа

# БҮЛЭГ 3. ХҮҮ, ТОРГУУЛИЙН ОРЛОГООС ХУВААРИЛСАН ХӨРӨНГИЙН 4.2 ХУВИЙГ ЗОРИУЛАЛТ БУСААР ЗАРЦУУЛСАН БАЙНА.

***Хүү, торгуулиас бүрдсэн орлогын тодорхой хувийг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, автозамын засвар шинэчлэлийн ажилд зарцуулсан байна.***

3.1. Аймаг, нийслэлийн хэмжээнд 2023, 2024 онд хүү, торгуулийн эх үүсвэрээс нийт 351,095.22 сая төгрөгийн орлого төвлөрч, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэл болон авто замын санд 104,240.99 сая төгрөг хуваарилж, 98,706.58 сая төгрөг зарцуулсан байна.

**Хүснэгт 11. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажил болон автозамын сангийн зарцуулалт**

(сая.төг)

| Зарцуулалт | Он | Орон нутаг | Нийслэл | Хуваарилсан | Зарцуулсан |
|---|---|---|---|---|---|
| ГХУСА | 2023 | 5,320.10 | 18,290.40 | 23,610.50 | 22,146.13 |
| | 2024 | 7,349.50 | 24,951.40 | 32,300.99 | 28,230.95 |
| Авто замын сан | 2023 | **6,649.54** | 11,700.00 | 18,349.70 | 18,349.70 |
| | 2024 | **5,679.70** | 24,300.00 | 29,979.80 | 29,979.80 |
| **Нийт** | | **24,998.84** | **79,241.80** | **104,240.99** | **98,706.58** |

Эх сурвалж: Аудитын судалгаа

***Торгуулийн орлогын зарцуулалтын талаар:***

3.2. Зөрчлийн тухай хуулиар ногдуулсан торгуулийн орлогыг тухайн байгууллага зарцуулахгүй, орон нутгийн төсөвт төвлөрүүлэх хуулийн зохицуулалттай байна.

3.3. ГХУСАЗСЗ-ийн төсөвт нийт 55,911.49 сая төгрөг хуваарилж, 50,377.08 сая төгрөг зарцуулсан байна. Үүнээс 2023 онд 23,610.50 сая төгрөгийг хуваарилж 22,146.17 сая төгрөг, 2024 онд 32,300.99 сая төгрөгийг хуваарилан 28,230.97 сая төгрөгийг тус тус зарцуулсан.

**Хүснэгт 12. ГХУСАЗСЗ-ийн төсвийн зарцуулалт** (сая.төг)

| № | Аймаг, нийслэл | 2023 он | | | 2024 он | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | Хуваарилсан | Зарцуулсан | Зөрүү | Хуваарилсан | Зарцуулалт | Зөрүү |
| 1 | Архангай | 265.30 | 216.30 | 49.00 | 370.90 | 338.33 | 32.57 |
| 2 | Баян-Өлгий | 236.30 | 219.10 | 17.20 | 185.30 | 169.80 | 15.50 |
| 3 | Баянхонгор | 239.90 | 216.63 | 23.27 | 560.00 | 544.60 | 15.40 |
| 4 | Булган | 327.80 | 327.80 | - | 530.00 | 533.70 | (3.70) |
| 5 | Говь-Алтай | 260.80 | 239.40 | 21.40 | 289.60 | 211.10 | 78.50 |
| 6 | Говь-сүмбэр | 361.30 | 361.30 | - | 413.00 | 412.80 | 0.20 |
| 7 | Дархан-Уул | 600.00 | 433.10 | 166.90 | 897.10 | 880.30 | 16.80 |
| 8 | Дорнод | 282.10 | 259.20 | 22.90 | 235.40 | 234.60 | 0.80 |
| 9 | Дорноговь | 402.60 | 380.70 | 21.90 | 564.70 | 560.30 | 4.40 |
| 10 | Дундговь | 138.00 | 137.90 | 0.10 | 164.80 | 164.70 | 0.10 |
| 11 | Завхан | 153.00 | 153.00 | - | 230.90 | 230.90 | - |
| 12 | Орхон | 467.00 | 428.00 | 39.00 | 600.00 | 440.70 | 159.30 |
| 13 | Өвөрхангай | 127.00 | 108.00 | 19.00 | 127.00 | 124.90 | 2.10 |
| 14 | Өмнөговь | 258.00 | 227.70 | 30.30 | 258.00 | 231.50 | 26.50 |
| 15 | Сүхбаатар | 161.80 | 153.10 | 8.70 | 421.10 | 385.30 | 35.80 |
| 16 | Сэлэнгэ | 220.00 | 219.70 | 0.30 | 482.00 | 481.60 | 0.40 |
| 17 | Төв | 170.00 | 164.80 | 5.20 | 180.00 | 163.00 | 17.00 |
| 18 | Увс | 81.00 | 81.00 | - | 81.00 | 68.80 | 12.20 |
| 19 | Ховд | 100.00 | 100.00 | - | 286.00 | 274.40 | 11.60 |
| 20 | Хөвсгөл | 353.40 | 353.40 | - | 315.70 | 315.70 | - |
| 21 | Хэнтий | 114.80 | 87.70 | 27.10 | 157.00 | 139.00 | 18.00 |
| 22 | Нийслэл | 18,290.40 | 17,278.34 | 1,012.06 | 24,951.49 | 21,324.94 | 3,626.55 |
| **Нийт** | | **23,610.50** | **22,146.17** | **1,464.33** | **32,300.99** | **28,230.97** | **4,070.02** |

Эх сурвалж: Аймаг, нийслэлийн ИТХ-ын тогтоолууд, аудитын судалгаа

3.4. ГХУСТХ-ийн 46 дугээр зүйлийн 46.1 дэх хэсэгт заасны дагуу гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд зориулсан хөрөнгийг дараах чиглэлээр зарцуулахаар тусгасан байна. Үүнд:

- ✓ *“Зөрчлийн тухай хуулийн холбогдох зүйл хэсэгт заасан зөрчилд оногдуулсан торгох шийтгэлийн биелүүлж, төсөвт төвлөрүүлсэн мөнгөн дүнгийн 20-иос*

*доошгүй хувьтай тэнцэх хэмжээний хөрөнгийг дүрс бичлэгийн техник, хэрэгсэл, зөрчил болон эрүүгийн хэрэг хянан шалгах байгууллагын мэдээллийн нэгдсэн системийг сайжруулах ажилд;*
- ✓ *20-иос доошгүй хувьтай тэнцэх хэмжээний хөрөнгийг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх бусад ажилд зориулан дараагийн жилийн төсөвт тусгах".*

**Дүрслэл 7. Зөрчлийн ангилал**




3.5. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд 2023, 2024 онуудад зарцуулсан 50,377.00 сая төгрөгийн 8.2 хувь буюу 4,116.96 сая төгрөгийг зориулалтын дагуу зарцуулаагүй байна. Тухайлбал: **Хавсралт 4**

*Хоол унааны зардалд зарцуулсан:*
- ➢ *УБ, Баянзүрх дүүргийн ИТХ-ын даргын 2023, 2024 оны захирамж 182.3 сая төгрөг;*
- ➢ *Баянхонгор аймгийн ИТХ-ын даргын 2023, 2024 оны захирамжуудаар 54.04 сая төгрөг;*
- ➢ *УБ, Сонгинохайрхан дүүргийн ИТХ-ын даргын захирамжаар 14.3 сая төгрөг;*
- ➢ *Дорноговь аймгийн Замын-Үүд, Сайхандулаан сумдын ИТХ-ын даргын захирамжаар 7.08 сая төгрөг;*
- ➢ *Нийслэлийн ИТХ-ын даргын захирамжаар 2.5 сая төгрөгийг цэвэр ус болон цайны зардалд тус тус зарцуулсан байна.*

*ГХУСАЗСЗ-ийн хөрөнгөөр гишүүн байгууллагуудын үндсэн үйл ажиллагааны зардлыг санхүүжүүлсэн:*
- ➢ *Нийслэлийн ИТХ-ын даргын 2023, 2024 оны захирамжаар /цагдаа, онцгой байдал, шүүх, хяналт шалгалтын газар, ХХЕГ, ШШГЕГ, Зэвсэгт хүчний жанжин штаб гэх мэт/ үндсэн үйл ажиллагаанд 768.09 сая төгрөг;*
- ➢ *УБ, Баянгол дүүргийн ИТХ-ын захирамжаар прокурорын газрын авто машин засахад 19.7 сая төгрөг;*
- ➢ *УБ, Баянзүрх дүүргийн ИТХ-ын даргын 2023 оны захирамжаар 19.08 сая төгрөг;*
- ➢ *Завхан аймаг, 2024 онд эрүүлжүүлэх байрны сургалтын өрөөний засвар хийх ажлыг 9.0 сая төгрөгөөр гүйцэтгэсэн.*

*Тоног төхөөрөмж худалдан авсан:*
- ➢ *Нийслэлийн ИТХ даргын 2023 оны захирамжаар үерийн ус соруулах насос, хоолой худалдан авахад 300.0 сая төгрөг;*
- ➢ *Дорноговь аймгийн ИТХ-ын ажлын албанд компьютер, дэлгэц худалдан авахад 86.68 сая төгрөг;*
- ➢ *УБ,Чингэлтэй дүүрэг, улсын бүртгэлийн хэлтсийн албан хэрэгцээнд 2023 онд 4 ширхэг иж бүрэн компьютер, 4 ширхэг өнгөт принтер худалдан авахад 16.7 сая төгрөг;*
- ➢ *УБ, Баянгол дүүрэг, Хөдөлмөр халамжийн үйлчилгээний хэлтэст ухаалаг дэлгэц худалдан авахад 4.09 сая төгрөгийг тус тус зарцуулсан.*

*Төлөвлөгөөнд тусгагдаагүй контент сургалт сурталчилгаа зохион байгуулсан:*
- ➢ *УБ,Чингэлтэй дүүргийн ИТХ-ийн салбар зөвлөлийн 35 гишүүн сайн туршлага судлах сургалтын зардалд 2023, 2024 онуудад 72.76 сая төгрөг;*
- ➢ *Говьсүмбэр аймаг, сумдын ГХУСАХЗ-ийн гишүүдийн туршлага судлах, тэмцээн уралдаан зохион байгуулах арга хэмжээний зардалд 32.9 сая төгрөг;*
- ➢ *УБ, Баянзүрх дүүргийн ИТХ-ын даргын2023 оны захирамжаар гамшиг ослоос урьдчилан сэргийлэх контентын төлбөрт 7.5 сая төгрөг;*

- *Дорноговь аймаг, Сайншанд сумын ИТХ-ын төлөөлөгчид, ажлын албаны албан хаагчид, сумын ЗДТГ-ын албан хаагчдын дунд сургалт, тэмцээнд зохион байгуулах зардалд 2.34 сая төгрөгийг тус тус зарцуулсан.*

*Бусад үйл ажиллагаа, зохион байгуулалтын арга хэмжээнд:*

- *Дархан-Уул аймаг зориулалт бусаар 118.4 сая төгрөг;*
- *УБ, Баянзүрх дүүргийн ИТХ-ын даргын 2023, 2024 оны захирамжуудаар “Тийболын” тэмцээний зардалд 42.55 сая төгрөг;*
- *УБ, Баянгол дүүрэг мод тарих арга хэмжээнд 19.9 сая төгрөг;*
- *Дорноговь аймгийн Алтанширээ сум гэр бүлийн өдөрлөг, “Алтан хонх” арга хэмжээнд 1.74 сая төгрөг; Даланжаргалан сум шатар, бөхийн тэмцээнд 0.9 сая төгрөг, Дэлгэрэх сум бөхийн барилдаан, жаргалтай гэр бүл өдөрлөгт 1.12 сая төгрөг, Хөвсгөл сум торгууль төлөхөд 0.3 сая төгрөг, хүүхдийн драмын жүжгийн тоглолтод 0.32 сая төгрөг, нийт 4.38 сая төгрөг;*
- *Баянхонгор аймгийн ИТХ-ын даргын 2024 оны захирамжаар “Крикет” тэмцээний зардалд 2.85 сая төгрөг, сэргээн засах эмчилгээнд 4.0 сая төгрөг, нийт 6.85 сая төгрөгийг тус тус зарцуулсан.*

*Анхан шатны баримтын бүрдэлгүй:*

- *УБ, Баянгол дүүрэг, 2024 онд ГХУСА-ын хүрээнд ажил гүйцэтгэх 811.84 сая төгрөгийн дүнтэй 93 удаагийн гэрээ байгуулж, сургалт зохион байгуулсан боловч гэрээ дүгнэсэн актгүй;*
- *УБ, Чингэлтэй дүүрэг, ГХУСА-д оролцсон албан хаагчдад 2023, 2024 онд 327.54 сая төгрөгийн урамшуулал олгосон боловч тайлан мэдээ дүгнээгүй, үр дүнг тооцоогүй;*
- *УБ, Баянгол дүүрэг, 2023 онд гэрээгээр гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зорилгоор дүүргийн ЕБС, хорооны иргэдэд цахим халдлагаас хамгаалах, гэр бүлийн сургалт, архинаас татгалзъя зэрэг сургалтуудыг зохион байгуулахад 276.42 сая төгрөг, цагдаагийн газарт энгэрийн камер худалдан авахад 13.06 сая төгрөг;*
- *Нийслэлийн ИТХ-ын даргын 2023, 2024 оны захирамжаар гишүүн байгууллага, албан хаагчдын урамшуулалд 220.50 сая төгрөг, гадаад албан томилолтод 124.89 сая төгрөгийг зарцуулсан боловч үр дүнг тооцсон баримтгүй;*
- *УБ, Хан-Уул дүүрэг ГХУСА-ын хүрээнд 2023, 2024 онд нийт 218.97 сая төгрөгийн гэрээний дүнтэй ажлууд, гэрээ дүгнэсэн актгүй.*

*Ил тод мэдээлээгүй:*

- *Нийслэлийн ИТХ-аас иргэний зөвлөлийн гишүүдэд 2023, 2024 онд 137.5 сая төгрөгийн урамшуулал олгосон боловч ХЗДХСайдын 2017 оны 155 тушаалаар баталсан Иргэний зөвлөлийн дүрмийн 4.3[13], 4.11[14], 4.12[15], 4.13[16] цахим хуудас, хэвлэл, мэдээллийн хэрэгсэл болон бусад хэлбэрээр олон нийтэд мэдээлээгүй.*

*Эдийн засгийн ангилал хооронд шилжүүлж, зарцуулсан:*

- *УБ, Баянзүрх дүүргийн ИТХ-аар 2023, 2024 оны захирамжуудаар нийт 102.64 төгрөг;*
- *Баянхонгор аймгийн ИТХ-ын даргын 2023 оны захирамжаар Тайвань улсад туршлага судлахад 10.18 сая төгрөг;*
- *УБ, Баянгол дүүрэг ИТХ-ын даргын 2024 оны захирамжаар Хятад улс руу алба томилолтоор ажиллаж, туршлага судлахад 4.73 сая төгрөг.*

[13] 4.3.Зөвлөл нь тухайн жилийн 12 дугаар сарын 20-ны өдрийн дотор дараа жилийн ээлжит хуралдаанаар хэлэлцэх асуудлын төлөвлөгөө боловсруулан баталж, цахим хуудсанд байршуулна

[14] 4.11.Хуралдаанаар хэлэлцсэн асуудал, хөтөлбөр, холбогдох мэдээллийг хуралдаан болсноос хойш ажлын 3 өдөрт багтаан цахим хуудсанд байршуулна

[15] 4.12.Зөвлөл хагас жилд хийж гүйцэтгэсэн ажлын тайлангаа 7 дугаар сарын 10ны өдрийн дотор, бүтэн жилд хийж гүйцэтгэсэн ажлын тайлангаа дараа оны 1 дүгээр сарын 15-ны өдрийн дотор цахим хуудас, хэвлэл, мэдээллийн хэрэгсэл болон бусад хэлбэрээр олон нийтэд хүртээмжтэй мэдээлнэ.

[16] 4.13.Зөвлөлийн гишүүнд олгосон урамшил, хуралдаанд оролцсон ирцийн мэдээллийг дараа жилийн 1 дүгээр сарын 15-ны өдрийн дотор цахим хуудсанд байршуулж нийтэд мэдээлнэ" заалтыг хэрэгжүүлэн ажиллаагүй байна.

3.6. Дээрх зөрчлүүд нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.6.6[17], 16 дугаар зүйлийн 16.5.5[18], Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.7[19] дахь заалтыг тус тус зөрчсөн байна. Аудитаар илэрсэн 4,116.96 сая төгрөгийн зөрчилд АНТАГ-аас 298.83 сая төгрөгийн 11 албан шаардлага, 3,818.13 сая төгрөгийн 47 зөвлөмжийг шалгагдагч байгууллагуудад хүргүүлсэн.

3.7. Авто замын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.2 дэх хэсэгт Нийслэл, орон нутгийн чанартай авто замын сангийн хөрөнгө дараах эх үүсвэрээс бүрдэхээр заасан байна Үүнд:

- *Авто тээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татвар;*
- *Нийслэл, орон нутгийн төсвөөс хуваарилсан хөрөнгө;*
- *Гадаадын зээл, тусламж, хандивын хөрөнгө;*
- *Нийслэл, орон нутгийн авто зам дээр хөдөлгөөний аюулгүй байдлын зөрчил гаргасан, авто замын талаарх хууль тогтоомжийг зөрчсөн этгээдэд ногдуулсан торгууль;*
- *Нийслэл, орон нутгийн авто зам, зогсоол ашигласны төлбөр;*
- *Авто замын зурвас газарт холбогдох зөвшөөрлийн дагуу үйлчилгээ эрхэлсний төлбөр;*
- *Бусад.*

3.8. Автозамын сан дээрх эх үүсвэрүүдээс бүрдэж, хөрөнгө нь автозамын ажилд хуваарилагдан зарцуулагддаг учир торгуулийн орлогын зарцуулалтыг тусад нь салган үзэх боломжгүй байна.

***Хүүгийн орлогын зарцуулалтын талаар:***

3.9. Аймаг, нийслэлийн хэмжээнд 2023 онд 2,022.36 сая төгрөг, 2024 онд 23,146.14 сая төгрөг, нийт 25,168.51 сая төгрөгийн хүүгийн орлого төвлөрсөн. Дээрх орлого нь татварын бус орлоготой нэгтгэгдэж, “орон нутгийн төсвийн суурь зарлага”-д зарцуулагддаг учир тусад нь салган үзэх боломжгүй байна.

***НД-ын харилцах дансны чөлөөт үлдэгдлийн хүү:***

3.10. Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 12 дугаар зүйлийн 12.3[20] дахь хэсэгт заасны дагуу 2023, 2024 онд нийт 42,092.90 сая төгрөгийн хүүгийн орлого төлөвлөж, 43,888.90 сая төгрөгийг төвлөрүүлсэн байна.

3.11. Хүүгийн орлогыг НДЕГ-ын даргын 2023 оны “*Заавар батлах тухай*” А/78, 2024 оны А/72 дугаар тушаалаар баталсан журам, аргачлалын дагуу нийгмийн даатгалын сангуудад хуваарилж зарцуулж байна.

**Хүснэгт 13. НД-ын хүүгийн хуваарилалт, зарцуулалт** (сая.төг)

| Он | Тэтгэвэр | Тэтгэмж | ҮОМШӨ | Ажилгүйдэл | Нийт |
|---|---|---|---|---|---|
| 2023 | 8,878.81 | 5,407.78 | 13,899.95 | 314.75 | 28,501.29 |
| 2024 | 3,918.83 | 2,826.82 | 8,514.05 | 127.91 | 15,387.61 |
| **Нийт** | **12,797.64** | **8,234.59** | **22,414.00** | **442.66** | **43,888.90** |

Эх сурвалж: Аудитын судалгаа

[17] 6.6.6.тухайн шатны төсвөөс санхүүжүүлэхээр хуулиар тогтоосон чиг үүргийг зөвхөн тухайн шатны төсвийн санхүүжилтээр хэрэгжүүлэх.
[18] 16.5.5.батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах;
[19] 46.7.Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажилд зориулсан хөрөнгийг хууль тогтоомжид заасанаас бусад зориулалтаар зарцуулахыг хориглоно.
[20] “Аймаг, дүүргийн нийгмийн даатгалын байгууллага нь нийгмийн даатгалын сан тус бүрийн орлогын зарцуулагдаагүй үлдэгдлийг нийгмийн даатгалын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын холбогдох дансанд сар бүр төвлөрүүлнэ”

***НШШГГ-ын арилжааны банканд байршуулсан хөрөнгөд бодогдсон хүү:***

3.12. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 114 дүгээр зүйлийн 114.1[21], 114.1.1[22], 114.1.2[23]-т төлбөр авагчийн хаяг тодорхойгүйгээс олгогдоогүй мөнгийг шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын дансанд нийтэд зарласнаас хойш хугацаанд иргэнд олгох бол 3 жил, хуулийн этгээдэд шилжүүлэх бол 1 жил хадгалах зохицуулалттай.

3.13. Нийслэлийн ШШГГ-ын арилжааны банканд байрших данснуудад төлбөр төлөгч иргэн, ААНБ-аас төвлөрсөн нийт 49,860.59 сая төгрөг 2024 оны байдлаар хуримтлагдсан байна.

3.14. Үүнээс 2010 оноос өмнөх эзэн холбогдогч тодорхойгүй 2,647.90 сая төгрөг, 2010 оноос хойш нийтэд зарласан боловч эзэн холбогдогч тодорхойгүй 215.6 сая төгрөг, нийт 2,863.50 сая төгрөгийн үлдэгдлийг улсын төсөвт төвлөрүүлээгүй нь дээрх хуулийн 114 дүгээр зүйлийн 114.3[24]-т заасантай нийцээгүй байна.

3.15. Төлбөр төлөгч иргэн, ААНБ-ын хуримтлагдсан мөнгөн хөрөнгийн үлдэгдэлд 2023 онд 3,124.86 сая төгрөг, 2024 онд 4,770.30 сая төгрөг, нийт 7,895.16 сая төгрөгийн хүүгийн орлого төвлөрснийг ШШГЕГ-ын үйл ажиллагааны орлогоор бүртгэн зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.7.2[25]-т заасантай нийцээгүй байна.

***Шийдвэрлэлт:***

1. Нийслэлийн ШШГГ-ын арилжааны банканд байршиж буй төлбөр төлөгч иргэн, ААНБ-ын хуримтлагдсан мөнгөн хөрөнгийн үлдэгдэлд тооцсон хүүгийн орлогыг орон нутгийн төсөвт төвлөрүүлээгүй зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэв.
2. Нийслэлийн ШШГГ-ын арилжааны банканд байрших данснуудад төвлөрсөн төлбөр төлөгч иргэн, ААНБ-ын нэр данс, гүйлгээний утга, зориулалт нь тодорхойгүй, нийтэд зарлаагүй, зарласан хугацаа хэтэрсэн 2,863.50 сая төгрөгийн мөнгөн хөрөнгийг улсын төсөвт төвлөрүүлэх төлбөрийн акт тогтоохоор шийдвэрлэв.

***Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр эдийн засаг, нийгэм, эрх зүй, зохион байгуулалтын нийтлэг арга хэмжээг зохион байгуулсан нь зөрчил буурахад нөлөө үзүүлсэн байна.***

3.16. Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажил нь гэмт хэрэг, зөрчлийн тухай мэдээллийг судалсны үндсэн дээр гэмт хэрэг, зөрчил үйлдэгдэхэд нөлөөлж байгаа шалтгаан, нөхцөл, хүчин зүйлсийг тогтоож, түүнийг арилгахад чиглэсэн эдийн засаг, нийгэм, эрх зүйн болон зохион байгуулалтын бусад арга хэмжээний нийлбэр байна.

3.17. Аудитын хамарсан хугацаанд цагдаагийн байгууллагад нийт 6593568 зөрчил бүртгэгдэж, 6491503 иргэн, ААНБ-д торгууль ногдуулсан байна.

---

[21]114.1.Төлбөр авагчийн хаяг тодорхойгүйгээс олгогдоогүй мөнгийг шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын дансанд нийтэд зарласнаас хойш дараахь хугацаанд хадгална:
[22]114.1.1.иргэнд олгох бол 3 жил;
[23]114.1.2.хуулийн этгээдэд шилжүүлэх бол 1 жил.
[24]114.3.Энэ хуулийн 114.1-д заасан хугацаа өнгөрсөн тохиолдолд мөнгийг улсын төсөвт шилжүүлнэ.
[25] 23.7.2 орон нутгийн өмчийн эд хөрөнгийг ашигласны төлбөр болон борлуулсны орлого, хүү, торгуулийн орлого

**Дүрслэл 8. Цагдаагийн байгууллагад бүртгэгдсэн зөрчлийн тоо**




3.18. ТЦА-нд 2023, 2024 онд нийт 3635473 зөрчил бүртгэгдэж 2024 онд өмнөх оноос 769277 зөрчил буюу 53.6 хувиар өссөн нь улсын хэмжээнд замын хөдөлгөөнд оролцож буй автомашины тоо нэмэгдсэн, ГХУСА-ын хүрээнд замын уулзваруудыг камержуулсан, иргэдээс гар утсаар ирүүлсэн зөрчлийг хянан баталгаажуулах зэрэг техник технологийн шийдлийг ашиглах боломж бүрдсэнтэй холбоотой байна.

3.19. Аймгуудын хэмжээнд цагдаагийн байгууллагад бүртгэгдсэн нийгмийн хэв журмыг зөрчсөн зөрчил 2023 онд 865601 бүртгэгдсэн бол 2024 онд 844990 болж өмнөх оноос 20611 буюу 2.3 хувиар, нийслэлд 566854 зөрчил буюу 65.7 хувиар, экологийн цагдаа, төмөр замын цагдаа зэрэг бусад газарт 17082 зөрчил буюу 31.7 хувиар тус тус буурсан байна.

3.20. Дээрх судалгаанаас үзэхэд гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлд тодорхой хэмжээний хөрөнгө хуваарилан зарцуулсан нь зөрчил буурахад нөлөөлжээ. Тухайлбал:

- ✓ *Баян-Өлгий аймагт мал хулгайлах гэмт хэрэг өмнөх оноос 52.6 хувиар, хөрөнгө завших гэмт хэрэг 82.6 хувиар, дээрэмдэх гэмт хэрэг 66.6 хувиар;*
- ✓ *Баянхонгор аймагт согтуугаар үйлдэгдэж буй гэмт хэрэг, зөрчил 30.5 хувиар;*
- ✓ *Дундговь аймагт хулгайлах гэмт хэрэг 60.0 хувь, залилах гэмт хэрэг 27.7 хувиар;*
- ✓ *Завхан аймагт гэмт хэрэг, зөрчил 2023 онд 19.0 хувь, 2024 онд 13.1 хувиар;*
- ✓ *Өмнөговь аймагт 2024 онд бүртгэгдсэн гэмт хэрэг, зөрчлийг өмнөх онтой харьцуулахад 7.3 хувиар;*
- ✓ *Увс аймагт мал хулгайлах гэмт хэргийн гаралт өмнөх онтой харьцуулахад 10.8 хувиар буурсан, иргэд, ААНБ-аас ирдэг гомдол мэдээллийн дуудлага 12.3 хувиар;*
- ✓ *Ховд аймагт 2024 оныг өмнөх онтой харьцуулахад эд хөрөнгөтэй /мал болон хөрөнгө өмчлөхтэй/ холбоотой гэмт хэргүүд 3.3-53.7 хувиар тус тус буурч;*
- ✓ *Өвөрхангай аймагт зөрчлийн тоо 2024 онд өмнөх оноос 7486-аар;*
- ✓ *Орхон аймаг согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодсон гэмт хэрэг үйлдэгчийн тоо өмнөх оноос 2023 онд 489-өөр, 2024 онд 833 болж буурсан байна.*

***Хүү, торгуулийн орлогын зарцуулалтыг татварын бус орлогын ангилалд тайлагнасан байна.***

3.21. Хүү торгуулийн орлого нь төсвийн ангиллаар татварын бус орлогод хамаарч байна. Төсвийн орлого, зарлагыг Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйл 5.4.1[26],

[26] 5.1.4.ил тод байдлыг хангасан байх;

Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 68 дугаар зүйлийн 68.3[27] зааснаар шилэн дансанд бүртгэж, ил тод тайлагнахаар хуульчилсан.

3.22. Шилэн дансанд хүү, торгуулийн орлогын зарцуулалтыг бүртгэж тайлагнахдаа орлогын нэр төрлөөр тайлагнаагүй, татварын бус орлогын ангилалд нэгтгэн тайлагнасан байна.

3.23. Аймаг нийслэлийн хэмжээнд шилэн дансны цахим хуудсанд мэдээлэл оруулсан байдлыг авч үзэхэд аймгууд 97.0 хувь, нийслэлд 58.0 хувийн хэрэгжилттэй байна. **Хавсралт 5**

**Хүснэгт 14. Шилэн дансанд мэдээлэл оруулсан байдал** (тоо)

| № | Орон нутаг | Хамрах он | Хуулиар оруулах мэдээлэл | Хугацаандаа оруулсан | Хугацаа хоцроосон | Огт мэдээлээгүй |
|---|---|---|---|---|---|---|
| 1 | Аймаг | 2023 | 195 | 186 | - | 9 |
| | | 2024 | 265 | 262 | - | 3 |
| 2 | Нийслэл | 2023 | 147 | 11 | 5 | 131 |
| | | 2024 | 182 | 180 | 2 | - |
| **Нийт** | | | **789** | **639** | **7** | **143** |

Эх сурвалж: Аудитын судалгаа

3.24. Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1[28], 19.2[29]-т заасан шаардлагын дагуу гурван жилд нэгээс доошгүй удаа хөндлөнгийн байгууллагаар үнэлгээ хийлгэх, уг байгууллагыг Зохицуулах зөвлөлийн баталсан журмаар сонгон шалгаруулах зохицуулалттай байна.

3.25. Гэвч ГХЗУСТХ хуульд заасан холбогдох журам өнөөг хүртэл батлагдаагүйгээс шалтгаалан хөндлөнгийн хяналт, олон нийтийн оролцоог хангах, хуулийн хэрэгжилтийг бодитоор үнэлэх нөхцөл бүрдээгүй байна.

[27] 68.3.Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Зөвлөлөөс баталсан тухайн жилийн төсвийг ил тод, олон нийтэд хүртээмжтэй байдлаар мэдээлнэ.

[28] 19.1.Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр авч хэрэгжүүлсэн ажил, арга хэмжээг улсын хэмжээнд болон Салбар болон Дэд зөвлөл, төрийн захиргааны болон хууль сахиулах байгууллагын түвшинд гурван жилд нэгээс доошгүй удаа хөндлөнгийн байгууллагаар үнэлүүлж, үйл ажиллагаанд нь дүгнэлт хийнэ.

[29] 19.2.Энэ хуулийн 19.1-д заасан байгууллага нь хүний эрх, эрх чөлөөг хамгаалах, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг, ашгийн бус, ашиг сонирхлын зөрчилгүй хуулийн этгээд байх бөгөөд түүнд тавих шаардлага, сонгон шалгаруулах журмыг Зохицуулах зөвлөл батална.

# БҮЛЭГ 4. ХҮҮ, ТОРГУУЛИЙН ОРЛОГЫН БҮРДҮҮЛЭЛТ, ЗАРЦУУЛАЛТАД ТАВИХ ХЯНАЛТЫГ ХАНГАЛТТАЙ ХЭРЭГЖҮҮЛЭЭГҮЙ БАЙНА.

***Орлого төвлөрүүлэгч зарим байгууллагууд дотоод мэдээллийн сан үүсгэсэн байна.***

4.1. Хүү, торгуулийн орлого төвлөрүүлэгч зарим байгууллагууд дотоодод ашигладаг мэдээллийн системийг нэвтрүүлж салбарын хэмжээний дата бааз, мэдээллийн нэгдсэн санг үүсгэсэн ч байгууллага хооронд мэдээлэл дамжуулах нэгдсэн систем бий болоогүй байна. Тухайлбал:

**Дүрслэл 9. Хүү, торгуулийн орлого төвлөрүүлэгч зарим байгууллагуудын салбарын хэмжээнд ашиглаж буй мэдээллийн систем, программ хангамжийн талаар**




4.2. Татварын удирдлагын “Tais” систем нь татварын ногдол, төлөлт, гүйцэтгэл зэрэг мэдээллийг агуулсан бол Гаалийн “Cais” систем нь гаалийн бүрдүүлэлт, татварын хувь хэмжээ, барааны мэдүүлэг, лабораторийн дүгнэлт зэрэг мэдээллүүдийг агуулсан байна.

4.3.Замын хөдөлгөөний зөрчилд ногдуулсан торгуулийг [http://torguuli.police.gov.mn/](http://torguuli.police.gov.mn/), [https://smartcar.mn/](https://smartcar.mn/) сайтуудаар дамжуулан төлөх бөгөөд татвар, торгууль, даатгал, хот хоорондын зам ашигласны хураамж, зогсоолын төлбөрийг төлөхөөр тусгаж, торгуулийн мэдээллийг иргэн харах боломжтойгоор системчилсэн байна.

**Дүрслэл 10. Замын хөдөлгөөн, тээврийн хэрэгсэлтэй холбоотой зөрчлийг бүртгэж буй байдал. Тухайлбал:**



4.4. “E-Mongolia”, “E-barimt”, “E-police”, Smartcar.mn “Токи”, “Гэрэгэ” зэрэг олон төрлийн системээр дамжуулан иргэн, ААНБ төлбөр, торгуулийг төлөх боломж бүрдсэн байна.

***Хяналтын систем нь орлого бүрдүүлэлтэд тодорхой хэмжээнд нөлөөлж байна.***

4.5. Замын хөдөлгөөнтэй холбоотой уулзвар гарц хаах, давхар эгнээ эргэх, эгнээ байр буруу эзлэх, урсгал сөрөх, хурд хэтрүүлэх, тэмдэг тэмдэглэгээ зөрчих зэрэг зөрчлүүд ихээр гардагтай холбоотойгоор замын хөдөлгөөний соёлыг дээшлүүлэх, зөрчлийг бууруулах, иргэдийн оролцоо хяналтыг нэмэгдүүлэх зорилготойгоор “E-police” системийг нэвтрүүлсэн байна.
Тус системээр дамжуулан 2023 онд 50959 зөрчилд 1,019.39 сая төгрөг, 2024 онд 93542 зөрчилд 1,638.21 төгрөгийн торгууль ногдуулсан байна.




4.6. Улсын ерөнхий прокурор болон Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2020 оны А/208 дугаар хамтарсан тушаалын дагуу “*Зөрчлийн бүртгэл, мэдээллийн сан*”-г 2022 оноос туршилтаар ашиглаж эхэлсэн ч 2025 оны байдлаар бүрэн ашиглалтад ороогүй туршилтын шатанд байна.

4.7. Цаашид хүү, торгууль оногдуулах, бүрдүүлэх эрх бүхий байгууллагуудын мэдээллийн уялдаа холбоог сайжруулах, бүртгэл, тайлан, хяналт-шинжилгээний хүрээнд байгууллага хооронд мэдээлэл дамжуулах нэгдсэн сан бий болгох шаардлага байна.

***Хугацаа хэтэрсэн 321,814.7 сая төгрөгийн торгуулийн орлого төлөгдөөгүй байна.***

4.8. Зөрчлийн тухай хуулийн 14.7 дугаар зүйлд заасны дагуу замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль тогтоомж зөрчсөн 2017-2024 онд хамаарах 299493 зөрчилд ногдуулсан 70,899.96 сая төгрөгийн торгууль төлөгдөөгүй байсан.

4.9. Зөрчлийн тухай хуулийн 3.8.4[30], Улсын ерөнхий прокурор, Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2024 оны А/43, А/72 дугаар хамтарсан тушаалаар баталсан *“Эрхийг хязгаарлах, эрх бүхий албан тушаалтан, шүүх болон эрх бүхий байгууллага хооронд мэдээлэл солилцох журам”*-ын 2.1[31]-д заасны дагуу цагдаагийн байгууллагаас холбогдох арга хэмжээ авсны үр дүнд 2025 оны 4 дүгээр сарын 17-ны өдрийн байдлаар дээрх торгуулиас 32,726.37 сая төгрөг буюу 46.2 хувийг төлүүлж, 38,173.40 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

[30] 4.Зөрчил үйлдсэн хүн, хуулийн этгээд тусгайлан олгогдсон зөвшөөрлийн дагуу үйл ажиллагаа явуулах, эрхээ хэрэгжүүлэх хууль, захиргааны хэм хэмжээний актаар тогтоосон журмыг байнга, эсхүл ноцтой зөрчсөн, эсхүл тусгайлан олгогдсон зөвшөөрлийн дагуу үйл ажиллагаа явуулах, эрхээ хэрэгжүүлэх журмыг зөрчсөн зөрчилд нь оногдуулсан шийтгэлийг биелүүлэхээс санаатайгаар зайлсхийсэн бол эрх хасах шийтгэлийг үндсэн шийтгэл дээр нэмж оногдуулна.
[31] 2.1.Зөрчил үйлдсэн хүн, хуулийн этгээд нь торгох шийтгэлийг хуульд заасан хугацаанд биелүүлээгүй бол зөрчлийн бүртгэл, мэдээллийн нэгдсэн санд бүртгэсэн мэдээллийг үндэслэн дараах эрхийг хязгаарлах ажиллагааг хэрэгжүүлнэ

**Хүснэгт 15. Цагдаагийн байгууллагаас 2017-2024 онд оногдуулсан торгуулийн үлдэгдэл**

(сая.төг)

| № | Байгууллага | Эхний үлдэгдэл | | Төлөгдсөн | | Үлдэгдэл | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | Зөрчлийн тоо | Мөнгөн дүн | Зөрчлийн тоо | Мөнгөн дүн | Зөрчлийн тоо | Мөнгөн дүн |
| 1 | ЦЕГ-ын ТЦА | 2294023 | 54,250.97 | 1262174 | 28,663.66 | 1031849 | 25,587.32 |
| 2 | ЗХУТ ОНӨТҮГ | 700912 | 16,648.79 | 162910 | 4,062.71 | 538002 | 12,586.08 |
| **Нийт** | | **2994935** | **70,899.76** | **1425084** | **32,726.37** | **1569851** | **38,173.40** |

Эх сурвалж: Цагдаагийн Ерөнхий газар судалгаа

4.10. Татварын ерөнхий газрын судалгаагаар 2024 оны эцсийн байдлаар 2012-2024 оныг хамарсан хугацаа хэтэрсэн торгуулийн үлдэгдэл 283,641.3 сая төгрөг байна.

***Эрх бүхий байгууллагаас хяналт шалгалт зохион байгуулсан ч хүү, торгуулийн орлогын бүрдүүлэлт, зарцуулалтад тавих хяналтыг хангалттай хэрэгжүүлээгүй байна.***

4.11. Төсвийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.36[32], 4.1.37[33], Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.8[34], 38.1[35], 38.2.6[36]-д заасны дагуу эрх бүхий байгууллагуудаас орлогын бүрдүүлэлт, зарцуулалтад хяналт тавихаар тусгажээ.

4.12. Эрх бүхий байгууллагуудаас 2023, 2024 онуудад дараах хяналт шалгалтыг хийсэн байна. Үүнд:

**Хүснэгт 16. Эрх бүхий байгууллагуудаас хяналт хэрэгжүүлсэн байдал** (тийм бол*, үгүй бол-)

| № | Аймаг, нийслэл | Аймаг, нийслэлийн ИТХ, ГХУСАЗСЗ | Аймаг, нийслэлийн ЗДТГ | Төрийн аудитын байгууллага | Дотоод аудитын алба | Төрийн бус байгууллага | Олон улсын байгууллага | Зөвлөл ТББ |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | Архангай | - | * | * | - | - | - | - |
| 2 | Баян-Өлгий | - | - | * | - | - | - | - |
| 3 | Баянхонгор | - | * | * | - | - | - | - |
| 4 | Булган | - | * | * | - | - | - | - |
| 5 | Говь-Алтай | - | * | * | - | - | - | - |
| 6 | Говьсүмбэр | - | * | * | - | - | - | - |
| 7 | Дархан-Уул | * | * | * | - | - | - | - |
| 8 | Дорноговь | * | - | * | * | - | - | - |
| 9 | Дорнод | * | - | * | * | - | - | - |
| 10 | Дундговь | - | - | * | - | - | - | - |
| 11 | Өвөрхангай | * | - | * | - | - | - | - |
| 12 | Өмнөговь | - | - | * | - | - | - | - |
| 13 | Завхан | - | - | * | - | - | - | - |
| 14 | Орхон | * | - | * | - | - | - | - |
| 15 | Сүхбаатар | - | - | * | - | - | - | - |
| 16 | Сэлэнгэ | - | * | * | - | - | - | - |
| 17 | Төв | - | - | * | - | - | - | - |
| 18 | Увс | - | - | * | - | - | - | - |
| 19 | Хөвсгөл | - | * | * | - | - | - | - |
| 20 | Ховд | - | * | * | - | - | - | - |
| 21 | Хэнтий | * | - | * | - | - | - | - |
| 22 | Нийслэл | * | * | * | * | - | - | - |

Эх сурвалж: Аудитын судалгаа

4.13. ГХУСАЗЗ нь улсын хэмжээнд хэрэгжүүлэх хөтөлбөр, төлөвлөгөөг боловсруулж, түүний биелэлтэд хяналт тавих, биелэлтийг хангуулах ажлыг зохион байгуулах чиглэлээр 2023 онд 21 аймаг, нийслэлийн 9 дүүрэг, 2024 онд 11 аймагт

[32] 4.1.36.Төсвийн ерөнхийлөн захирагч нь өөрийн эрхлэх асуудлын хүрээний төсвийг төлөвлөх, батлагдсан төсвийг хууль тогтоомжийн дагуу хуваарилах, хяналт тавих, захиран зарцуулах, гүйцэтгэлийг тайлагнах эрх бүхий этгээд байна.
[33] 4.1.37.Төсвийн төвлөрүүлэн захирагч нь төсвийн ерөнхийлөн захирагчаас хуваарилсан чиг үүргийн төсвийг төлөвлөх, төсвийн шууд захирагчид хуваарилах, хяналт тавих, хууль тогтоомжийн дагуу захиран зарцуулах, гүйцэтгэлийг тайлагнах эрх бүхий этгээд байна.
[34] 46.8.Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажилд зориулсан хөрөнгийн төлөвлөлт, хуваарилалт, зарцуулалтад Зохицуулах зөвлөл, төрийн аудитын байгууллага, санхүү, төсвийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага, тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурал болон төсвийн тухай хууль тогтоомжид заасан эрх бүхий этгээд хяналт тавина
[35] 38.1.Төрийн бүх шатны байгууллага, албан тушаалтан гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор хөтөлбөр, төлөвлөгөө боловсруулах, түүнийг хэрэгжүүлэх явцад олон нийтийн оролцоог хангана
[36] 38.2.6.гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлын төсвийн зарцуулалтад олон нийтийн оролцоо, хяналтыг бий болгох

ажиллаж, хэрэгжүүлж буй үйл ажиллагаа, үр дүнг хэлэлцэж, тайлан мэдээг салбар болон дэд зөвлөлөөс тухай бүрд авч ажилласан байна.

4.14. Хяналт хэрэгжүүлсэн байдлыг авч үзвэл ТАБ-аас 22, аймаг, нийслэлийн ИТХ-аас 7, ЗДТГ-аас 10, дотоод аудитын албанаас 3 удаагийн хяналт шалгалтыг хийсэн байна. Тухайлбал:

- *Дорнод аймгийн ИТХ-аас ГХУСАЗСЗ-ийн 2023, 2024 оны жилийн эцсийн тайланд хяналт хэрэгжүүлсэн;*
- *Орхон аймгийн ИТХ-аас 2023, 2024 оны хүү торгуулийн орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл, ГХУСАЗСЗ-ийн тайланг хэлэлцэж хяналт хэрэгжүүлсэн;*
- *Нийслэлийн дотоод аудитын албанаас хүү, торгуулийн орлогын төлөвлөлт, гүйцэтгэл, хуримтлагдсан үлдэгдэлд хяналт хэрэгжүүлсэн;*
- *ЦЕГ-ын дэд дарга бөгөөд НЦУГ-ын даргын баталсан “Хэсэгчилсэн хяналт шалгалт” явуулах удирдамжийн дагуу 2024 онд дүүргүүдийн цагдаагийн газар, хэлтсийн үнэт цаасны баримтад төлөвлөгөөт хяналт шалгалт хийсэн байна.*

4.15. Аймаг, нийслэлийн санхүү, төрийн сангийн нэгжээс шийтгэлийн хуудасны бүртгэл, хадгалалт, зарцуулалтад тавих хяналт хангалтгүй, шийтгэлийн хуудас олгосон тооцоо нийлээгүй нь Засгийн газрын 2021 оны 135 дугаар тогтоолоор баталсан “*Шийтгэлийн болон шийтгэлээс чөлөөлөх хуудасны маягт, хэрэглэх журам”*-ын 2.2[37], 2.11[38] дэх заалтуудтай нийцэхгүй байна.

**Хүснэгт 17.Шийтгэлийн хуудасны тооцоо нийлсэн байдал** (тоо.ширхэг)

| Шийтгэлийн хуудасны зарлагын тоо | | | | | Тооцоо нийлсэн эсэх | |
|---|---|---|---|---|---|---|
| № | Аймаг, нийслэл | 2023 он | 2024 он | **Нийт** | тийм | үгүй |
| 1 | Архангай | 600 | 1600 | **2200** | - | + |
| 2 | Баян-Өлгий | 3500 | 1000 | **4500** | - | + |
| 3 | Баянхонгор | 500 | 1700 | **2200** | - | + |
| 4 | Булган | 1000 | - | **1000** | - | + |
| 5 | Говь-Алтай | 5100 | - | **5100** | - | + |
| 6 | Говьсүмбэр | - | - | **-** | - | + |
| 7 | Дархан-Уул | - | 1500 | **1500** | - | + |
| 8 | Дорноговь | 5520 | 2000 | **7520** | - | + |
| 9 | Дорнод | - | 2000 | **2000** | - | + |
| 10 | Дундговь | 3340 | - | **3340** | - | + |
| 11 | Өвөрхангай | 2500 | - | **2500** | - | + |
| 12 | Өмнөговь | 7360 | 1350 | **8710** | - | + |
| 13 | Завхан | - | - | **-** | - | + |
| 14 | Орхон | 990 | 800 | **1790** | - | + |
| 15 | Сүхбаатар | 2390 | 2100 | **4490** | - | + |
| 16 | Сэлэнгэ | 1600 | 4000 | **5600** | + | - |
| 17 | Төв | 7870 | 1000 | **8870** | + | - |
| 18 | Увс | 4300 | 800 | **5100** | - | + |
| 19 | Хөвсгөл | 3000 | - | **3000** | - | + |
| 20 | Ховд | 600 | 1900 | **2500** | - | + |
| 21 | Хэнтий | 1700 | 1600 | **3300** | - | + |
| 22 | Нийслэл | 121844 | 162680 | **284524** | + | - |
| **Нийт** | | **173714** | **186030** | **359744** | **3** | **19** |

Эх сурвалж: ХЗДХЯ-аас олгосон шийтгэлийн хуудас, аудитын судалгаа

4.16. Хууль зүй дотоод хэргийн яам болон аймаг, нийслэлээс 2023, 2024 онд зарлагадсан 359744 шийтгэлийн хуудасны тооцоог шалгахад Нийслэл болон Сэлэнгэ, Төв аймгийн ЗДТГ-аас бусад аймгууд эрх бүхий байгууллагатай тооцоо нийлээгүй нь дээрх журмын 2.11.[39]-т заасныг хэрэгжүүлээгүй байна.

[37]2.2.Шийтгэлийн хуудсыг хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас эрхлэн хэвлүүлж, аймаг, нийслэлийн санхүү, төрийн сан хариуцсан нэгжид албан хүсэлтийн дагуу бүртгэлээр олгох бөгөөд түүнийг үнэт цаасны нэгэн адил бүртгэж, хадгалалт, зарцуулалтад тухайн эрх бүхий байгууллагын дарга, нягтлан бодогч хяналт тавина.
[38]2.11.Шийтгэлийн хуудас олгосон тооцоог хийхэд "Хүснэгт-1", Шийтгэлийн хуудасны зарцуулалтын тайланг гаргахад "Хүснэгт-2"-ыг тус тус ашиглана.
[39]2.11.Шийтгэлийн хуудас олгосон тооцоог хийхэд "Хүснэгт-1", Шийтгэлийн хуудасны зарцуулалтын тайланг гаргахад "Хүснэгт-2"-ыг тус тус ашиглана.

# АУДИТЫН ДҮГНЭЛТ

**Аудитаар илрүүлсэн зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтүүдийг хийж байна. Үүнд:**

1. Хүү, торгуультай холбоотой харилцааг зохицуулж байгаа зарим хууль, эрх зүйн актын уялдаа, нийцлийг хангуулж шинэчлэн сайжруулах шаардлагатай байна.
2. Сангийн яамнаас хянасан хүү, торгуулийн орлогын төлөвлөгөөг тухайн шатны ИТХ-аас бодит нөхцөл байдал, судалгаанд үндэслээгүй, харилцан адилгүй хувь хэмжээгээр өсгөж, бууруулан баталсан байна.
3. Төсвийн тухай хуульд заасан хүү, торгуулийн орлогыг орон нутгийн төсөвт төвлөрүүлэх чиг үүрэг бүрэн хэрэгжээгүй байна.
4. Хүү, торгуулийн орлогоос Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд болон авто замын санд хуваарилах санхүүжилтийг дутуу олгосон, хуваарилсан хөрөнгийн 4.2 хувийг зориулалтын дагуу зарцуулаагүй нь нийгмийн хэв журмыг бэхжүүлэх, соён гэгээрүүлэх үндсэн зорилтын үр дүнг бууруулж байна.
5. Байгууллага хоорондын мэдээллийн нэгдсэн сан бүрдээгүй, хүү, торгууль ногдуулсан нэгж, нэхэмжлэлийн дугаар тодорхойгүйгээс орлогын төлөвлөгөөний биелэлтийг байгууллага бүрээр гаргах боломжгүй байна.
6. Хүү, торгуулийн орлогын бүрдүүлэлт, зарцуулалтад тавих хяналт хангалтгүйгээс 321,814.7 сая төгрөгийн хугацаа хэтэрсэн торгуулийн орлого төлөгдөөгүй байна.

Аудитаар нийт 32,306.86 сая төгрөгийн зөрчил илэрч, үүнээс 2,873.10 сая төгрөгийн зөрчилд 2 төлбөрийн акт, 12,410.76 сая төгрөгийн зөрчилд 41 албан шаардлага, 17,013.41 сая төгрөгийн зөрчилд 163 зөвлөмжийг шалгагдагч байгууллагуудад хүргүүлсэн байна.

## АУДИТЫН ЗӨВЛӨМЖ

**Аудитын дүн, дүгнэлтэд үндэслэн дараах зөвлөмжийг өгч байна. Үүнд:**

### САНГИЙН ЯАМАНД:

1. Хүү, торгуулийн орлого бүрдүүлэгч байгууллагуудын хооронд мэдээллийн санг бий болгож, хууль, эрх зүйн актын нийцлийг сайжруулан, үйл ажиллагааг нь нэгдсэн бодлогоор хангах;
2. Улсын төсөвт төвлөрч буй хүү торгуулийн орлогыг харьяалах орон нутгийн төсөвт төвлөрүүлж, төрийн сангийн хүү, торгуулийн орлогын дансны эх үүсвэрийг ангилах;
3. Хугацаа хэтэрсэн торгуулийн үлдэгдлийг үе шаттайгаар барагдуулах арга хэмжээ авч ажиллах.

### ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧ НАРТ:

1. Хүү, торгуулийн орлого бүрдүүлэгч байгууллагуудын тооцоо судалгаа, зөрчлийн бүртгэл, нэгдсэн мэдээлэл, бодит нөхцөл байдалд тулгуурлан орлогыг төлөвлөх;
2. Хүү, торгуулийн орлогыг холбогдох хууль тогтоомжийг баримтлан хуваарилах, орлогыг зориулалтын дагуу зарцуулах;
3. Хүү торгуулийн орлого төлөвлөх, бүрдүүлэх, хуваарилах, зарцуулах, хэрэгжүүлэх үйл ажиллагаанд холбогдох хууль тогтоомжийг чанд мөрдөж, хяналтын чиг үүргээ хэрэгжүүлэх.

# ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН САНАЛ

Нийслэлийн Засаг дарга, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газраас тайлангийн төсөлтэй танилцаад албан бичгээр санал ирүүлсэн. Сангийн яам, Нийслэлийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлаас Төрийн аудитын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2-д заасан хугацаанд санал ирүүлээгүй.

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ
ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ ЕРӨНХИЙ ГАЗАР

Бага тойруу 13/1, Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160
Утас: 26 63 32, Факс: (976-11) 32 99 33,
Цахим шуудан: info@cd.gov.mn,
Цахим хуудас: www.cd.gov.mn

2025.09.26 № 01/2488

танай ____________-ны №____________-т

НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН
ГАЗРЫН ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
Г.НАНДИНЖАРГАЛ ТАНАА

Танай газраас ирүүлсэн “Хүү, торгуулийн орлогын бүрдүүлэлт, зарцуулалт” сэдэвт гүйцэтгэлийн аудитын /НТАГ-2025/27-ШТА-ГА/ тайлангийн төсөлд өгөх санал болон холбогдох аудитын материалын хамт хүргүүлж байна.

Хавсралт [illegible]... хуудастай.

ДАРГА, БРИГАДЫН
ГЕНЕРАЛ Б.НАНДИНБОЛОР

1501083957

МОНГОЛ УЛС
НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА

Наадамчдын зам 1200, Арцатын ам,
23 дугаар хороо, Хан-Уул дүүрэг,
Улаанбаатар хот, 17100
Утас: (976-11) 32 39 77, 32 71 99
Цахим хуудас: www.ulaanbaatar.mn

2025.09.26 № 01/6160

танай ____________-ны №____________-т

НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН
ГАЗРЫН ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
Г.НАНДИНЖАРГАЛ ТАНАА

“Хүү, торгуулийн орлогын бүрдүүлэлт, зарцуулалт” сэдэвт гүйцэтгэлийн аудитын (НТАГ-2025/27-ШТА-ГА) тайлангийн төсөлтэй танилцан, Төрийн аудитын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2 дахь хэсэгт заасны дагуу тайланд тусгах саналаа хавсралтаар хүргүүлж байна.

Хавсралт 1 хуудастай.

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА
БӨГӨӨД УЛААНБААТАР ХОТЫН
ЗАХИРАГЧ Х.НЯМБААТАР

1725080779

# ХАВСРАЛТ

## Хавсралт 1

### Улс, орон нутгийн төсөвт хүү, торгуулийн орлогын эзлэх хувь

(тэрбум.төг)

| Орлогын нэр төрөл | МУ | | | Нийслэл | | | Аймаг дундаж | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | 2023 он | 2024 он | НИЙТ | 2023 он | 2024 он | НИЙТ | 2023 он | 2024 он | НИЙТ |
| НИЙТ ОРЛОГО | 23,294.89 | 29,670.80 | **52,965.69** | 2,205.04 | 3,091.10 | **5,296.14** | 251.09 | 191.98 | **443.07** |
| Хүү, торгуулийн орлого | 309.13 | 409.15 | **718.28** | 98.90 | 134.32 | **233.22** | 2.09 | 2.49 | **4.58** |
| Эзлэх хувь | 1.3 | 1.4 | **1.4** | 4.5 | 4.3 | **4.4** | 0.8 | 1.3 | **1.0** |

(тэрбум.төг)

| № | Аймаг | Нийт орлого | | Гүйцэтгэл | | Нийт орлогод хүү, торгуулийн эзлэх хувь | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | 2023 он | 2024 он | 2023 он | 2024 он | 2023 он | 2024 он | Дундаж |
| 1 | Архангай | 143.41 | 81.35 | 0.39 | 0.35 | 0.3 | 0.4 | 0.4 |
| 2 | Баян-Өлгий | 42.67 | 71.29 | 1.16 | 1.23 | 2.7 | 1.7 | 2.2 |
| 3 | Баянхонгор | 161.54 | 100.46 | 1.42 | 0.91 | 0.9 | 0.9 | 0.9 |
| 4 | Булган | 98.65 | 91.68 | 1.72 | 1.22 | 1.7 | 1.3 | 1.5 |
| 5 | Говь-Алтай | 100.47 | 79.68 | 1.10 | 1.05 | 1.1 | 1.3 | 1.2 |
| 6 | Говьсүмбэр | 335.82 | 31.71 | 0.62 | 0.99 | 0.2 | 3.1 | 1.7 |
| 7 | Дархан-Уул | 180.02 | 100.31 | 2.93 | 2.81 | 1.6 | 2.8 | 2.2 |
| 8 | Дорноговь | 194.02 | 158.57 | 3.29 | 4.43 | 1.7 | 2.8 | 2.2 |
| 9 | Дорнод | 149.83 | 97.32 | 1.09 | 2.12 | 0.7 | 2.2 | 1.5 |
| 10 | Дундговь | 65.39 | 95.46 | 9.70 | 1.13 | 14.8 | 1.2 | 8.0 |
| 11 | Өвөрхангай | 178.82 | 94.44 | 1.80 | 1.65 | 1.0 | 1.7 | 1.4 |
| 12 | Өмнөговь | 2,269.73 | 1,879.08 | 4.86 | 19.82 | 0.2 | 1.1 | 0.6 |
| 13 | Завхан | 81.86 | 85.16 | 0.76 | 0.91 | 0.9 | 1.1 | 1.0 |
| 14 | Орхон | 354.13 | 311.45 | 2.25 | 2.06 | 0.6 | 0.7 | 0.6 |
| 15 | Сүхбаатар | 116.07 | 77.75 | 1.13 | 0.94 | 1.0 | 1.2 | 1.1 |
| 16 | Сэлэнгэ | 51.45 | 119.37 | 2.22 | 2.24 | 4.3 | 1.9 | 3.1 |
| 17 | Төв | 175.54 | 140.94 | 2.73 | 3.76 | 1.6 | 2.7 | 2.1 |
| 18 | Увс | 125.81 | 81.15 | 1.06 | 1.53 | 0.8 | 1.9 | 1.4 |
| 19 | Хөвсгөл | 92.91 | 116.94 | 1.40 | 1.02 | 1.5 | 0.9 | 1.2 |
| 20 | Ховд | 148.12 | 110.17 | 1.11 | 1.08 | 0.7 | 1.0 | 0.9 |
| 21 | Хэнтий | 206.57 | 107.29 | 1.20 | 1.03 | 0.6 | 1.0 | 0.8 |
| **Нийт** | | **5,272.83** | **4,031.57** | **43.94** | **52.28** | **0.8** | **1.3** | **1.1** |

## Хавсралт 2

### Аймаг, нийслэл, дүүргийн ИТХ-ын төсөв баталсан тогтоолд хүү, торгуулийн орлогыг тусгасан байдал (2023, 2024)

(сая.төг)

| № | Аймаг, нийслэл | 2023 оны төсөвт баталсан тогтоол | Батлагдсан дүн | 2024 оны төсөвт баталсан тогтоол | Батлагдсан дүн |
|---|---|---|---|---|---|
| 1 | Архангай | 2022.11.30 №13, 2023.06.27 №17 | 2,845.9 | 2023.12.01 №08, 2024.09.12 №07 | 1,685.4 |
| 2 | Баян-Өлгий | 2022.12.02 №132, 2023.10.16 №197 | 213.0 | 2023.12.04 №221, 2024.09.24 №262 | 1,187.3 |
| 3 | Баянхонгор | 2022.12.02 №12/55 2023.07.03 №15/42 | 2,120.6 | 2023.12.04 17/57, 2024.09.16 21/06 | 1,331.00 |
| 4 | Булган | 2022.12.03 №XII/21, 2023.08.04 №XVII/01 | 2,540.2 | 2023.12.05 №XIX/08 2024.09.12 XXV/05 | 666.0 |
| 5 | Говь-Алтай | 2023.12.01 №64 | 3,601.0 | 2023.12.01 №71, 2024.12.05 №13 | 1,704.0 |
| 6 | Говьсүмбэр | 2022.12.02 №11, 2023.08.04 №03 | 900.0 | 2023.12.01 №05, 2024.09.23 №03 | 1,362.0 |
| 7 | Дархан-Уул | 2022.12.02 №58, 2024.11.24№ 53 | 1,702.6 | 2023.11.24 №54, 2024.11.15 №09 | 2,165.0 |
| 8 | Дорноговь | 2022.12.03 №10/06, 2023.07.04 №12/05 | 2,286.0 | 2023.12.05 №15/08, 2024.09.23 №19/01 | 1,128.0 |
| 9 | Дорнод | 2022.12.02 №13/11, 2023.12.04 №19/09 | 1,132.0 | 2023.12.04 19/11 2024.07.05 22/01 | 1,382.0 |
| 10 | Дундговь | 2022.12.05 №04, 2023.06.27 №25 | 388.0 | 2023.12.04 №46, 2024.09.07 №40 | 11,500.0 |
| 11 | Завхан | 2022.12.05 №58, | 1,009.2 | 2023.12.02 №94, | 835.0 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | 2023.06.29 №81 | | 2024.10.22 №09 | |
| 12 | Орхон | 2022.12.02 13/09, 2023.07.08 11/04 | 1,450.0 | 2023.12.02 №17/04, 2024.09.11 №18/05 | 1,850.0 |
| 13 | Өвөрхангай | 2022.12.02 15/06, 2023.11.30 23/14 | 5,250.0 | 2023.11.30 23/14, 2024.09.11 29/01 | 1,391.0 |
| 14 | Өмнөговь | 2022.12.01 №9/15, 2023.08.09 №13/11 | 2,037.0 | 2023.12.01 15/11, 2024.09.18 19/28 | 1,059.0 |
| 15 | Сүхбаатар | 2022.12.02 №07, 2023.07.26 №01 | 600.0 | 2023.12.04 06, 2024.09.19 №07 | 2,240.0 |
| 16 | Сэлэнгэ | 2022.12.05 №82, 2023.07.26 №118, 2023.12.04 №141 | 750.0 | 2023.12.04 №142, 2024.09.23 №180 | 1,750.0 |
| 17 | Төв | 2022.12.05 №02, 2023.08.04 №02 | 947.3 | 2023.12.04 №03, 2024.09.09 №03 | 1,271.0 |
| 18 | Увс | 2022.12.02 №11/03, 2023.07.21 14/01 | 850.0 | 2023.11.30 16/04, 2024.09.18 21/01 | 1,050.0 |
| 19 | Ховд | 2022.12.01 10/06, 2023.06.27 12/02 | 1,113.5 | 2023.12.04 14/04, 2024.09.09 18/03 | 1,901.0 |
| 20 | Хөвсгөл | 2022.12.02 №08, 2023.04.05 №07 | 1,237.0 | 2023.12.01 №04, 2024.09.23 XXVIII/37 | 885.4 |
| 21 | Хэнтий | 2022.12.05 №206, 2023.07.03 №03 | 1,382.0 | 2023.12.05 №02, 2024.09.02 №02 | 1,761.0 |
| 22 | Нийслэл | 2023.08.09 №96 | 94,375.6 | 2024.12.25 №24/32 | 153,237.5 |
| 23 | Баянгол | 2023.12.04 №16 | 2,900.0 | 2024.11.25 №05 | 4,500.0 |
| 24 | Баянзүрх | 2023.08.25 №78 | 1,600.0 | 2024.11.08 №09 | 3,551.0 |
| 25 | Багануур | 2023.12.18 №29 | 2,085.0 | 2024.11.21 №09 | 2,210.0 |
| 26 | Багахангай | 2023.07.07 А/22 | 200.0 | 2024.09/27 А/21 | 300.0 |
| 27 | Налайх | 2023.09.07. №26/22 | 1,223.5 | 2024.11.08 02/10 | 1,851.3 |
| 28 | Сүхбаатар | 2023.12.08 №11/66 | 2,072.4 | 2024.12.26 №02/14 | 3,133.8 |
| 29 | Сонгинохайрхан | 2023.07.07 14/03 | 972.0 | 2024.10.01 №20/0 | 2,000.0 |
| 30 | Хан-Уул | 2023.12.19 №25 | 6,000.0 | 2024.10.04 №26 | 3,000.0 |
| 31 | Чингэлтэй | 2023.11.01 №16 | 1,675.3 | 2024.09.25 №43 | 5,732.1 |
| **Нийт** | | | **145,756.5** | | **219,619.8** |

## Хавсралт 3

## ГХУСА-д төсөв батлаагүй болон дутуу тусгасан сумууд

(сая.төг)

| № | Аймаг | Зардал (дутуу, хуваарилсан сумууд) | Тухайн жилүүдэд хуваарилах дүн | | Хуваарилсан дүн | | 2023 он (дутуу хуваарилсан) | | 2024 он (дутуу хуваарилсан) | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | 2023 он | 2024 он | 2023 он | 2024 он | Дүн | Хувь | Дүн | Хувь |
| 1 | Булган | Булган | 112.0 | 190.0 | 62.0 | 133.2 | 50.0 | 44.6 | 56.8 | 29.9 |
| | | Бугат | 8.8 | - | 7.0 | - | 1.8 | 20.5 | - | - |
| | | Баянагт, | 4.8 | - | 4.0 | - | 0.8 | 16.7 | - | - |
| | | Баяннуур, | 33.2 | - | 10.0 | - | 23.2 | 69.9 | - | - |
| | | Бүрэгхангай | 18.0 | - | 17.2 | - | 0.8 | 4.4 | - | - |
| | | Дашинчилэн | 8.0 | - | 6.4 | - | 1.6 | 20 | - | - |
| | | Могод, | 4.0 | - | 1.8 | - | 2.2 | 55 | - | - |
| | | Сайхан | 3.6 | - | 2.0 | - | 1.6 | 44.4 | - | - |
| | | Хутаг-өндөр | 32.0 | - | 20.0 | - | 12.0 | 37.5 | - | - |
| | | Хишиг-өндөр | 4.8 | - | 2.2 | - | 2.6 | 54.2 | - | - |
| | | Сэлэнгэ | 9.5 | - | 2.0 | - | 7.5 | 78.9 | - | - |
| | | Орхон | 16.4 | - | 6.4 | - | 10.0 | 61 | - | - |
| | | Хангал | 16.2 | - | 8.8 | - | 7.4 | 45.7 | - | - |
| | | Жаргалан | - | 1.1 | - | 0.5 | - | - | 0.6 | 53.7 |
| | | Тонхил | 1.7 | - | 0.9 | - | 0.8 | 47.7 | - | - |
| | | Төгрөг | 3.6 | 2.0 | 0.5 | 1.7 | 3.1 | 86 | 0.3 | 16.7 |
| | | Хөхморьт | 2.2 | - | 2.0 | - | 0.2 | 7.4 | - | - |
| | | Цээл | 1.5 | 1.7 | 0.5 | 1.6 | 1.0 | 67.1 | 0.1 | 4.8 |
| | | Шарга | 2.5 | 4.3 | 0.2 | 0.2 | 2.3 | 91.9 | 4.1 | 95.4 |
| | | Эрдэнэ | 1.5 | 2.8 | 0.3 | 1.0 | 1.2 | 79.7 | 1.8 | 64.8 |
| | | Есөнбулаг | 134.1 | 166.7 | 70.0 | 66.4 | 64.1 | 47.8 | 100.3 | 60.2 |
| 3 | Дорноговь | Айраг | 27.5 | 43.3 | 3.6 | 12.9 | 23.9 | 86.9 | 30.4 | 70.2 |
| | | Даланжаргалан | 5.7 | 7.7 | 5.0 | 7.5 | 0.7 | 12.3 | 0.2 | 2.6 |
| | | Дэлгэрэх | 2.1 | - | 1.6 | - | 0.5 | 23.8 | - | - |
| | | Эрдэнэ | 12.5 | 2.1 | 2.0 | 2.0 | 10.5 | 84 | 0.1 | 4.8 |
| | | Замын-Үүд | 123.2 | 274.2 | 36.0 | 35.0 | 87.1 | 70.7 | 197.1 | 71.9 |
| 4 | Завхан | Асгат | 3.6 | - | 3.5 | - | 0.1 | 2.8 | - | - |
| | | Баянхайрхан | - | 0.2 | - | - | - | - | - | - |
| | | Тэлмэн | 10.4 | - | 6.0 | - | 4.4 | 42.3 | - | - |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | Эрдэнэхайрхан | - | 0.2 | - | - | - | - | - | - |
| 5 | Өвөрхангай | Арвайхээр | 268.3 | 381.1 | 60.0 | 90.0 | 208.3 | 77.6 | 291.1 | 76.4 |
| | | Хайрхандулаан | 2.2 | - | 2.0 | - | 0.2 | 9.1 | - | - |
| | | Бүрд | 6.9 | - | 4.0 | - | 2.9 | 42 | - | - |
| | | Тарагт | - | 11.6 | - | 11.5 | - | - | 0.1 | 0.9 |
| | | Уянга | 25.7 | 30.5 | 25.0 | 27.9 | 0.7 | 2.7 | 2.6 | 8.5 |
| | | Төгрөг | 3.4 | 6.9 | 2.0 | 2.0 | 1.4 | 41.2 | 4.9 | 71 |
| | | Өлзийт | 4.4 | 2.3 | 1.0 | 0.5 | 3.4 | 77.3 | 1.8 | 78.3 |
| | | Сант | 6.1 | 4.5 | 6.0 | 3.6 | 0.1 | 1.6 | 0.9 | 20 |
| | | Нарийнтээл | 2.8 | 3.1 | 2.0 | 2.4 | 0.8 | 28.6 | 0.7 | 22.6 |
| | | Зүүнбаян-Улаан | 7.6 | 14.5 | 5.0 | 3.0 | 2.6 | 34.2 | 11.5 | 79.3 |
| | | Хужирт | 9.5 | 12.5 | 3.0 | 3.0 | 6.5 | 68.4 | 9.5 | 76 |
| | | Хархорин | 159.8 | 197.7 | 15.0 | 65.6 | 144.8 | 90.6 | 132.1 | 66.8 |
| | | Баруунбаян-Улаан | 11.4 | 25.8 | 11.0 | 20.0 | 0.4 | 3.5 | 5.8 | 22.5 |
| 6 | Сүхбаатар | Асгат | 1.5 | 5.4 | 1.0 | 2.0 | 0.5 | 33.3 | 3.4 | 63 |
| | | Баяндэлгэр | - | 12.3 | - | 10.0 | - | - | 2.3 | 18.7 |
| | | Мөнххаан | 25.1 | - | 20.0 | - | 5.1 | 20.3 | - | - |
| | | Онгон | - | 6.6 | - | 6.0 | - | - | 0.6 | 9.1 |
| | | Түмэнцогт | 24.0 | - | 15.0 | - | 9.0 | 37.5 | - | |
| | | Уулбаян | 4.2 | 6.7 | 3.0 | 5.0 | 1.2 | 28.6 | 1.7 | 25.4 |
| | | Сүхбаатар | 5.8 | 6.7 | 5.0 | 5.0 | 0.8 | 13.8 | 1.7 | 25.4 |
| | | Халзан | - | 1.5 | - | 0.6 | - | - | 0.9 | 60 |
| | | Эрдэнэцагаан | 9.1 | 21.5 | 8.8 | 20.0 | 0.3 | 3.3 | 1.5 | 7 |
| | | Баруун-Урт | - | 207.7 | - | 205.0 | - | - | 2.7 | 1.3 |
| 7 | Сэлэнгэ | Шаамар | 43.1 | - | 40.0 | - | 3.1 | 7.2 | - | - |
| | | Хүдэр | 12.0 | 9.8 | 1.5 | 3.0 | 10.5 | 87.5 | 6.8 | 69.4 |
| | | Сүхбаатар | 122.5 | 151.0 | - | 5.0 | - | - | 146.0 | 96.7 |
| | | Сант | 15.1 | 19.5 | 3.0 | 5.0 | 12.1 | 80.1 | 14.5 | 74.4 |
| | | Сайхан | 53.6 | 111.7 | 2.0 | 2.0 | 51.6 | 96.3 | 109.7 | 98.2 |
| | | Орхон | 21.3 | 25.7 | 2.0 | 12.0 | 19.3 | 90.6 | 13.7 | 53.3 |
| | | Мандал | 219.6 | 186.5 | 20.0 | 20.0 | 199.6 | 90.9 | 166.5 | 89.3 |
| | | Ерөө | 34.5 | 51.4 | 5.0 | 2.0 | 29.5 | 85.5 | 49.4 | 96.1 |
| | | Баянгол | 61.7 | 141.1 | 2.0 | 5.0 | 59.7 | 96.8 | 136.1 | 96.5 |
| | | Баруунбүрэн | - | 13.8 | - | 1.5 | - | - | 12.3 | 89.1 |
| | | Булган | 112.0 | 190.0 | 62.0 | 133.2 | 50.0 | 44.6 | 56.8 | 29.9 |
| | | Бугат | 8.8 | - | 7.0 | - | 1.8 | 20.5 | - | - |
| | | Баянагт, | 4.8 | - | 4.0 | - | 0.8 | 16.7 | - | - |
| | | Баяннуур | 33.2 | - | 10.0 | - | 23.2 | 69.9 | - | - |

**Хавсралт 4**

## Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд баталсан төсвийг зориулалт бусаар зарцуулсан зөрчил (2023, 2024 он)

| № | Аймаг, нийслэлийн ГХУСАЗСЗ-ууд | Алдаа зөрчлийн товч утга | Мөнгөн дүн (төгрөг) |
|---|---|---|---|
| 1 | Баянхонгор | ИТХ-ын даргын 2023 онд 13, 2024 онд 23 нийт 36 захирамжаар ГХУСАЗСЗ-ийн төлөвлөгөөнд тусгагдсан сургалт, зөвлөгөөний хоол, цайны зардалд 50,594.460 төгрөгийг зарцуулсан.<br>Энэ нь төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь заалт, Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.7 дахь заалтыг зөрчсөн байна. | 50,594,600 |
| 2 | Баянхонгор | ИТХ-ын даргын 2023 оны 24 дүгээр захирамжаар ГХУСАЗСЗ-ийн хөрөнгөөр хугацаат цэргийн албан хаагчдыг эргэсэн байна.<br>Энэ нь төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.6.6, 16 дугаар зүйлийн 16.5.5, дахь заалт, Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.7 дахь заалтыг зөрчсөн байна. | 3,451,500 |
| 3 | Баянхонгор | ИТХ-ын даргын 2023 оны 08,13 дугаар захирамжуудаар Тайвань улсад туршлага судлахад 10.2 сая төгрөгийн зардлыг 21090102 буюу бараа ажил үйлчилгээний бусад зардлаас зарцуулсан байна.<br>Энэ нь Сангийн сайдын 2021 оны 10 дугаар сарын 29-ний өдрийн 190 дугаар тушаалаар батлагдсан “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар”-ыг зөрчсөн байна. | 10,182,600 |
| 4 | Баянхонгор | ИТХ-ын даргын 2024 оны 08 дугаар захирамжаар ГХУСАЗСЗ хөрөнгөөр Сэргээн засах эмчилгээнд хамруулсан.<br>Энэ нь төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.6.6, 16 дугаар зүйлийн 16.5.5, дахь заалт, Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.7 дахь заалтыг зөрчсөн байна. | 4,000,000 |
| 5 | Баянхонгор | ИТХ-ын даргын 2024 оны 12 дугаар захирамжаар ГХУСАЗСЗ хөрөнгөөр Нэгдсэн арга хэмжээ Крикет тэмцээнд оролцсон.<br>Энэ нь төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.6.6, 16 дугаар зүйлийн 16.5.5, дахь заалт, Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.7 дахь заалтыг зөрчсөн байна. | 2,850,000 |

| | | | |
|---|---|---|---|
| 6 | Говьсүмбэр | Аймаг, сумын ГХУСАХЗ-г гадаад, дотоод туршлага судлах, тэмцээн уралдаан зохион байгуулах арга хэмжээнд зарцуулсан. | 32,900,000 |
| 7 | Дорноговь | Аймгийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлөөс 2023-2024 онд нийт 86.6 сая төгрөгийг Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, журамд заагдаагүй зориулалтаар зарцуулсан байна. Үүнд:<br>1. Аймгийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын цагдан хорих байранд хүмүүжиж байгаа хүмүүжигчдэд гарын бэлэг<br>2. Батлан хамгаалах яамны Стратегийн бодлого, төлөвлөлтийн газрын даргаар ахлуулсан ажлын хэсгийн хүндэтгэлийн зардал, мөнгөн аяга<br>3. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын цагдан хорих байрны болон хоол үйлдвэрлэлийн өрөө, тасалгааны засвар<br>4. Аймгийн ИТХ-ын ажлын албанд компьютер, дэлгэц худалдан авах зардал<br>5. Аймаг, сумдын ИТХ-ын төлөөлөгчид, ажлын алба, сумдын Засаг дарга нарт сургалт зохион байгуулах гэх мэт. | 86,683,640 |
| 8 | Дорноговь | Алтанширээ сумын ГХУСАЗСЗ-өөс гэр бүлийн өдөрлөг, Алтан хонх зэрэг үр дүнг нь тодорхойлох боломжгүй арга хэмжээнд 1.749.500 төгрөгийг Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, журамд заагдаагүй зориулалтаар зарцуулсан байна. | 1,749,500 |
| 9 | Дорноговь | Даланжаргалан сумын ГХУСАЗСЗ-өөс 2023, 2024 онд үр дүнг нь тодорхойлох боломжгүй шатар, бөхийн тэмцээнд 900.000 төгрөгийг, хантааз худалдан авахад 400.000 төгрөгийг, хамтарсан багийн үйл ажиллагаанд 300.000 төгрөгийг нийт 1.600.000 төгрөгийг Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, журамд заагдаагүй зориулалтаар зарцуулсан байна. | 1,600,000 |
| 10 | Дорноговь | Дэлгэрэх сумын ГХУСАЗСЗ-өөс 2023, 2024 онд Иргэдээ сонсъё, Төлөөлөгчдийн өдөрлөг арга хэмжээ зохион байгуулах, Үндсэн хууль батлагдсан өдөртэй холбогдуулан бөхийн барилдаан, Жаргалтай гэр бүл зэрэг үр дүнг нь тодорхойлох боломжгүй нийт 1.120.000 төгрөгийг Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, журамд заагдаагүй зориулалтаар зарцуулсан байна. | 1,120,000 |
| 11 | Дорноговь | Замын-Үүд сумын ГХУСАЗСЗ-өөс 2023, 2024 онуудад 2.406.700 төгрөгийг зөвлөлийн хуралдааны хоолны зардалд, 1.000.000 төгрөгийг цагдаагийн албан хаагчдын нөхөн сэргээх эмчилгээний зардалд, 2.000.000 төгрөгийг Шүүгчийн зөвлөгөөний зардалд Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, журамд заагдаагүй зориулалтаар зарцуулсан байна. | 5,406,700 |
| 12 | Дорноговь | Сайншанд сумын ГХУСАЗСЗ-өөс 2023, 2024 онуудад нийт 2.339.721 төгрөгийг Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, журамд заагдаагүй зориулалтаар зарцуулсан байна. Үүнд:<br>1. Сайншанд сумын ИТХ-ын төлөөлөгчид, ажлын албан хаагчид болон сумын ЗДТГ-ын албан хаагчдын дунд ИТХ-ын хяналтын чиг үүрэг, Засаг даргатай харилцах харилцаа сэдэвт сургалт, тэмцээнд зохион байгуулах<br>2. ИТХ-н ажлын албан хаагчид, тэдний гэр бүлд "Гэр бүлийн үнэ цэнэ" уулзалт хэлэлцүүлэг зохион байгуулах<br>3. Сургуулийн өмнөх боловсрол, Ерөнхий боловсролын сургуулиудын эмч, эрүүл мэндийн хичээлийн сургагч багш нарт эрүүл мэндийн боловсрол олгох чадавхжуулах зэрэг үр дүнг нь тодорхойлох боломжгүй арга хэмжээг санхүүжүүлсэн байна. | 2,339,720 |
| 13 | Дорноговь | Сайхандулаан сумын ГХУСАЗСЗ-өөс 2023, 2024 онуудад зөвлөлийн хуралдааны хоолны зардал, автомашины засварт 1,675,950 төгрөгийг Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, журамд заагдаагүй зориулалтаар зарцуулсан байна. | 1,675,950 |
| 14 | Дорноговь | Хатанбулаг сумын ГХУСАЗСЗ-өөс 2023 онд "Их говийн нууц" хадны зургийн үзэсгэлэнд оролцох хадны зураг хэвлүүлэх ажилд 1,052,100 төгрөгийг Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, журамд заагдаагүй зориулалтаар зарцуулсан байна. | 1,052,100 |
| 15 | Дорноговь | Хөвсгөл сумын ГХУСАЗСЗ-өөс 2023, 2024 онуудад торгууль төлөхөд 300,000 төгрөгийг, Нэг ангийнхан сургамжит хүүхдийн драмын жүжгийн тоглолтод 326,000 төгрөгийг Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, журамд заагдаагүй зориулалтаар зарцуулсан байна. | 626,000 |
| 16 | Дундговь | Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны зардлыг зориулалт бусаар зарцуулсан. | 72,946,620 |
| 17 | Завхан | 2024 онд эрүүлжүүлэх байрны сургалтын өрөөний засвар хийх ажлыг төлөвлөж 9 сая төгрөгөөр гүйцэтгэсэн нь Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 46.5 дахь заалтыг зөрчсөн байна | 9,000,000 |
| 18 | Дархан | Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын зардлыг Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.5-д заасныг үндэслэн зарцуулаагүй зориулалтын бусаар зарцуулсан байна. | 118,408,840 |
| 19 | Нийслэл | Нийслэлийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлийн ажлын албаны төсвөөс 2023 онд 11, 2024 онд 6, нийт 17 удаагийн гүйлгээгээр төлөвлөгөөнд тусгагдсан сургалт, зөвлөгөөний хоол, цайны зардалд 2,575,950.0 төгрөгийг зориулалт бусаар зарцуулсан байна. Энэ нь төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь заалт, Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.7 дахь заалтыг зөрчсөн байна. | 2,575,950 |
| 20 | | НИТХ-ын даргын 2023 оны 7 захирамж, 2024 оны 6 захирамжаар ГХУСАЗСЗ-ийн хөрөнгөөр 11 гишүүн байгууллагуудын үндсэн үйл ажиллагааны зардлыг санхүүжүүлсэн. Энэ нь төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь заалт, Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.7 дахь заалтыг зөрчсөн байна. | 768,997,390 |

| | | | |
|---|---|---|---|
| 21 | | Нийслэлийн ИТХ-ын даргын 2023 оны А/25, А/38 захирамж, 2024 оны А/22, А/21, А/40, А/61 дугээр захирамжуудаар ГХУСАЗСЗ-ийн төсвөөс төлөвлөгөөнд тусгагдсан дагуу нийт 124.8 сая төгрөгөөр гадаад улс руу албан томилолтоор явсан нь ГХУСАЗСЗ-ийн үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгасан ажлыг эдийн засгийн ангиллыг нь зөв тусгаагүй гадаад албан томилолтын зардалд төлөвлөж, тайлагнаагүй нь төсвийн тухай хуулийн 70.3 дахь хэсэгт заасныг зөрчсөн байна. | 124,893,106 |
| 22 | | НИТХ-ын даргын 2023/07/07-ны А/101 дүгээр захирамжаар Гамшгаас хамгаалах, өндөржүүлсэн бэлэн байдлын үед иргэдийн амь нас, эрүүл мэнд, авто зам, замын байгууламж болон авто тээврийн хөдөлгөөнд аюул учрах шалтгаан нөхцөл арилгахад нэн шаардлагатай 300,000,000.00 төгрөгийг Нийслэлийн ГХУСАЗСЗ-ийн зардлаас гарган үерийн ус соруулах насос, хоолойг худалдан авч төсвийг зориулалт бусаар зарцуулсан. Энэ нь төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь заалт, Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.7 дахь заалтыг зөрчсөн байна. | 300,000,000 |
| 23 | | НИТХ-ын даргын 2023 оны 4 захирамж, 2024 оны 3 захирамжаар гишүүн байгууллага, НИТХ-ын албан хаагч нарыг Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажилд идэвхтэй оролцон тодорхой ажил зохиож, үр дүнд хүрсэн эсэх нотлох баримтгүй урамшуулал олгосон. Энэ нь Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.1 "Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажилд идэвхтэй оролцон тодорхой ажил зохиож, үр дүнд хүрсэн хүн, хуулийн этгээдийг урамшуулна" заалттай нийцэхгүй байна. | 220,500,000 |
| 24 | | НИТХТ-ийн 2021 оны 155 тогтоолоор Иргэний зөвлөлийн бүрэлдэхүүний тоог шинэчлэн тогтоож, 7 иргэдийг томилсон. 2023 онд 51.8 сая төгрөг, 2024 онд 85.7 сая төгрөгийг Иргэний зөвлөлийн гишүүдийн урамшуулалд олгосон. Иргэдийн зөвлөл ажиллах хугацаандаа дараа жилийн ээлжит хуралдаанаар хэлэлцэх асуудлын төлөвлөгөө, хуралдаанаар хэлэлцэх асуудал, хөтөлбөр, хагас, бүтэн жилийн ажлын тайлан, зөвлөлийн гишүүнд олгосон урамшуулал, ирцийн мэдээллийг цахим хуудас, хэвлэл мэдээлэл болон бусад хэлбэрээр олон нийтэд хүртээмжтэй мэдээлсэн эсэх нь баримтаар нотлогдоогүй. Энэ нь ХЗДХ Сайдын 2017 оны 155 тушаалаар баталсан Иргэний зөвлөлийн дүрмийн:<br>"4.3.Зөвлөл нь тухайн жилийн 12 дугаар сарын 20-ны өдрийн дотор дараа жилийн ээлжит хуралдаанаар хэлэлцэх асуудлын төлөвлөгөө боловсруулан баталж, цахим хуудсанд байршуулна.<br>4.11.Хуралдаанаар хэлэлцсэн асуудал, хөтөлбөр, холбогдох мэдээллийг хуралдаан болсноос хойш ажлын 3 өдөрт багтаан цахим хуудсанд байршуулна.<br>4.12.Зөвлөл хагас жилд хийж гүйцэтгэсэн ажлын тайлангаа 7 дугаар сарын 10ны өдрийн дотор, бүтэн жилд хийж гүйцэтгэсэн ажлын тайлангаа дараа оны 1 дүгээр сарын 15-ны өдрийн дотор цахим хуудас, хэвлэл, мэдээллийн хэрэгсэл болон бусад хэлбэрээр олон нийтэд хүртээмжтэй мэдээлнэ.<br>4.13.Зөвлөлийн гишүүнд олгосон урамшил, хуралдаанд оролцсон ирцийн мэдээллийг дараа жилийн 1 дүгээр сарын 15-ны өдрийн дотор цахим хуудсанд байршуулж нийтэд мэдээлнэ" заалтыг хэрэгжүүлэн ажиллаагүй байна. | 137,654,200 |
| 25 | УБ, Баянгол дүүрэг | 2023 онд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зорилгоор дүүргийн ЕБС, болон хорооны иргэдэд цахим халдлагаас хамгаалах, гэр бүлийн сургалтууд, архинаас татгалзъя зэрэг сургалтуудыг зохион байгуулахад 35 удаагийн шууд ажил эрхлэх гэрээгээр 276,422.5 мянган төгрөгийн анхан шатны баримт материал бүрдүүлэлт дутуу гэрээ дүгнэсэн акт үйлдээгүй байна. Мөн БГД-н цагдаагийн газарт 13,066.0 мянган төгрөгийг энгэрийн камер худалдан авч цагдаагийн байгууллагад шилжүүлсэн боловч хүлээн авсан байгууллагын орлогын падаан байхгүй байна. Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.4-д "хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажаагүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх", 13 дугаар зүйлийн 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно." гэж заасантай нийцэхгүй байна. | 289,488,500 |
| 26 | | 2023 онд БГД-ийн прокурорын газрын авто машин засахад 19,700.0 мянган төгрөг зарцуулсан.<br>Энэ нь Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.5 “Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд зориулсан хөрөнгийг дараах чиглэлээр зарцуулна: 46.5.1-46.5.11 дэх заалтууд, Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т "Нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна.", 16.5.5-т "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах;" гэж заасантай тус тус нийцэхгүй байна. | 19,700,000 |
| 27 | | 2024 онд Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд 93 удаагийн шууд ажил эрхлэх гэрээр 811,838.0 мянган төгрөгийн сургалт зохион байгуулсан бөгөөд анхан шатны баримт материал бүрдүүлэлт дутуу гэрээ дүгнэсэн акт үйлдээгүй байна. | 811,838,000 |
| 28 | | 2024 онд БГД-ийн Хөдөлмөр халамжийн үйлчилгээний хэлтэст ухаалаг дэлгэц авч өгсөн 4,900.0 мянган төгрөгийн гүйлгээний баримт, орлогын падаан анхан шатны баримт байхгүй, БНХАУ-д 7 хоног ажлын албаны дарга албан томилолтоор 4,733.1 мянган төгрөг, Мод тарих үйл ажиллагаанд 19,900.0 мянган төгрөг зарцуулжээ.<br>Энэ нь Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.5 “Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд зориулсан хөрөнгийг дараах чиглэлээр зарцуулна: 46.5.1-46.5.11 дэх заалтууд, Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т "Нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн | 29,533,100 |

| | | | |
|---|---|---|---|
| | | бүрэлдэхүүн хэсэг байна.", 16.5.5-т "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах;" гэж заасантай тус тус нийцэхгүй байна. | |
| 29 | УБ, Баянзүрх дүүрэг | Дүүргийн даргын 2023 онд 9, 2024 онд 10 нийт 19 удаагийн захирамжаар ГХУСАЗСЗ-ийн төлөвлөгөөнд тусгагдсан сургалт, зөвлөгөөний хоол, цайны зардалд 182,329,755 төгрөгийг зарцуулсан байна. Энэ нь төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь заалт, Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.7 дахь заалтыг зөрчсөн байна. | 182,329,755 |
| 30 | | Дүүргийн ИТХ-ын даргын 2023 оны захирамжаар ГХУСАЗСЗ-ийн хөрөнгөөр харьяа салбар байгууллагуудын үндсэн үйл ажиллагааны зардлыг санхүүжүүлсэн. /БЗД-ийн Эрүүл мэндийн нэгдлийн гамшгаас хамгаалах сургалт/ төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь заалт, Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.7 дахь заалтыг зөрчсөн байна. | 19,800,000 |
| 31 | | Дүүргийн ИТХ-ын даргын 2023 оны А/110-р захирамжаар ГХУСАЗСЗ-ийн хөрөнгөөр Гамшиг ослоос урьдчилан сэргийлэх контентын төлбөрийг төлсөн. Энэ нь төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь заалт, Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.7 дахь заалтыг зөрчсөн байна. | 7,500,000 |
| 32 | | Дүүргийн ИТХ-ын даргын 2023, 2024 оны нийт 10 удаагийн захирамжаар ГХУСАЗСЗ хөрөнгөөр Нэгдсэн арга хэмжээ Тийболын тэмцээний зардал түүний санхүүжилтийг олгосон байна. Энэ нь төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь заалт, Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.7 дахь заалтыг зөрчсөн байна. | 42,559,280 |
| 33 | | Дүүргийн ИТХ-аар 2023 онд 4, 2024 онд 6 удаагийн захирамжуудаар ГХУСАЗСЗ-ийн хөрөнгөөр төлөвлөгөөнд тусгагдсан дагуу нийт 102,643,831 төгрөгөөр гадаад улс руу албан томилолтоор явсан нь ГХУСАЗСЗ-ийн үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгасан ажлыг эдийн засгийн ангиллыг нь зөв тусгаагүй гадаад албан томилолтын зардалд төлөвлөж, тайлагнаагүй нь төсвийн тухай хуулийн 70.3 дэх хэсэгт заасныг зөрчсөн байна. | 102,643,831 |
| 34 | УБ, Сонгинохайрхан дүүрэг | Дүүргийн ИТХ-ын даргын 2023 онд 1 удаагийн захирамжаар ГХУСАЗСЗ-ийн төлөвлөгөөнд тусгагдсан сургалт, зөвлөгөөний хоол, цайны зардалд 14370000 төгрөгийг зарцуулсан байна. Энэ нь төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь заалт, Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.7 дахь заалтыг зөрчсөн байна. | 14,370,000 |
| 35 | УБ, Хан-Уул дүүрэг | ХУД-ийн ИТХ-ийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх салбар зөвлөл батлагдсан төсвийг зарцуулахдаа 2023 онд 135.2 сая төгрөгийн гэрээний дүнтэй ажил гүйлгээний санхүүгийн анхан шатны баримт дутуу байна. Үүнд:<br>- Ажил гүйцэтгэх гэрээ, нэхэмжлэхээр гүйцэтгэгч байгууллагад мөнгө шилжүүлсэн 11 иргэн, аж ахуйн нэгжид 12 удаагийн гүйлгээгээр 97.6 сая төгрөг шилжүүлсэн. Гэрээ дүгнэсэн акт, зарлагын баримт, орлогод авсан нь баримтаар нотлогдоогүй.<br>- 10 байгууллагын 37.6 сая төгрөгийн гэрээний гүйцэтгэсэн ажил, үйлчилгээ нь зарлагын баримт нь нотлогдоогүй.<br>2024 онд 83.7 сая төгрөгийн гэрээний дүнтэй 14 ажлын гэрээ дүгнэсэн акт байхгүй төлбөрийг шилжүүлсэн байна.<br>Энэ нь Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 20 дугаар зүйлийн *"20.3.Хөтөлбөр, төлөвлөгөөний хэрэгжилтэд түүнийг баталсан байгууллага, албан тушаалтан хяналт тавина"* гэснийг мөрдөж ажиллаагүй байна. | 218,972,763 |
| 36 | УБ, Чингэлтэй дүүрэг | Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлийн гишүүд болон гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд оролцсон албан хаагчдад 2023 онд 111,635.0 мянган төгрөг, 2024 онд 215,917.8 мянган төгрөгийн нийт 327,552.8 мянган төгрөгийн урамшууллыг олгожээ. Урамшуулал олгохдоо тодорхой ажил зохиож үр дүнг тооцсон тайлан мэдээг сар, хагас жил, бүтэн жилээр дүгнээгүй, үр дүнг тооцоогүй, тайлан байхгүй байхад урамшуулал олгосон.<br>Энэ нь Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.5.2.-т *"энэ хуулийн 34 дүгээр зүйлд заасны дагуу гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд идэвхтэй оролцсон хүн, хуулийн этгээдийг шагнаж, урамшуулах;"* 34.1.-т *"Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажилд идэвхтэй оролцон тодорхой ажил зохиож, үр дүнд хүрсэн хүн, хуулийн этгээдийг урамшуулна."* гэж заасан боловч тодорхой ажил зохиож үр дүнг тооцсон тайлан мэдээ сар, хагас жил, бүтэн жилээр байхгүй байхад урамшуулал олгосон нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 10.2.-т *"Үндэсний зөвлөл, хороо, комисс, ажлын хэсгийн гишүүнд үндсэн ажлын цалин хөлснөөс гадуур ажлын хөлс, урамшуулал олгохыг хориглоно"* гэж заасантай нийцэхгүй байна. | 327,552,800 |
| 37 | | ЧД-ийн ИТХ-ийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлийн 8 гишүүд Япон улсын Парламентын тогтолцоо, хууль зүйн яамны үйл ажиллагаатай танилцах, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх сайн туршлагаас суралцах зорилгоор 2023 онд 36,083.2 мянган төгрөгөөр томилолтоор ажилласан, 2024 онд ЧД-БНСУ-ын Инчон хотын Ёнсу дүүрэг хооронд байгуулсан санамж бичгийн хүрээнд тус дүүрэгт зохион байгуулагдах хүүхэд хамгааллын бодлого төслийн үйл ажиллагаанд дүүргийн ГХУСАЗСЗ-ийн 4 гишүүн 15,919.5 мянган төгрөгийг томилолтоор, БНХАУ-ын Хөх хотод Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх сайн туршлага судлах зорилгоор нэр бүхий 23 албан хаагчид вагоны билетийн зардал болох 4,140.0 мянган төгрөгийг ТОСОН ЗААМАР ОД ХХК-руу шилжүүлсэн, ЧД-ийн гадаад харилцаа, хамтын ажиллагаа хөгжүүлэх ажлын хүрээнд БНТУ-ын Анталья хоттой хамтын ажиллагаа эхлүүлж, камерын хяналтын системийг ашиглан гэмт хэргийг илрүүлэх, гаралтыг бууруулах талаар харилцан мэдээлэл, туршлага солилцох арга хэмжээнд оролцохоор ЧД-ийн | 72,762,800 |

| | | | |
|---|---|---|---|
| | | Цагдаагийн 1, 2 дугаар хэлтсийн дарга, ГХУСАЗСЗ-ийн ажилтан 3 албан хаагчид томилолтоор 16,620.12 төгрөгийг нийт 2024 онд 36,679.6 мянган төгрөгийг зарцуулсан байна. Нийт 2023-2024 онуудад 72,762.80 мянган төгрөгийн гадаад томилолтын зардалд зарцуулсан байна.<br>Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн *"15.2.7.сургалт, семинар, хурал, зөвлөгөөнийг амралт, сувилал, жуулчны баазад зохион байгуулахгүй байх, шаардлагатай бол хот суурин газарт зориулалтын хурлын танхимд, эсхүл цахимаар зохион байгуулах зэргээр түрээс, шатахуун, албан томилолтын зардлыг хэмнэх"* гэж заасантай тус тус нийцэхгүй байна. | |
| 38 | | 2023 онд Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлөөс ЧД-ийн Улсын бүртгэлийн хэлтсийн албан хэрэгцээнд "Цахим үндэстэн" хөтөлбөрийн хүрээнд 16,700.0 мянган төгрөгөөр 4 ширхэг иж бүрэн компьютер, 4 ширхэг өнгөт принтер авч өгсөн байна. Энэ нь Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.5.4-т *"гэмт хэрэгтэй тэмцэх чиг үүрэг бүхий байгууллагын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд болон шүүхийн шинжилгээний байгууллагаас хуульд заасан чиг үүргээ хэрэгжүүлэхэд шаардлагатай техник хэрэгсэл, тоног төхөөрөмжийн зардлыг санхүүжүүлэх;"* гэж заасантай нийцэхгүй байна. | 16,700,000 |
| **Нийт** | | | **4,116,959,245** |

**Хавсралт 5**

## Шилэн дансны цахим хуудсанд мэдээлэл оруулсан байдал

(сая.төг)

| № | Аймаг, нийслэл | 2023 он | | | | | 2024 он | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | Хуулиар оруулах мэдээлэл | Хугацаандаа оруулсан | Хугацаа хоцроосон | Огт мэдээлээгүй | Мөнгөн дүн | Хуулиар оруулах мэдээлэл | Хугацаандаа оруулсан | Хугацаа хоцроосон | Огт мэдээлээгүй | Мөнгөн дүн |
| 1 | Архангай | 20 | 20 | - | - | - | 6 | 6 | - | - | - |
| 2 | Баян-Өлгий | 18 | 18 | - | - | - | - | - | - | - | - |
| 3 | Баянхонгор | 16 | 16 | - | - | 54.90 | 22 | 22 | - | - | 84.00 |
| 4 | Булган | - | | - | - | - | - | - | - | - | - |
| 5 | Говь-Алтай | - | | - | - | - | - | - | - | - | - |
| 6 | Говьсүмбэр | - | | - | - | 361.30 | - | - | - | - | 412.80 |
| 7 | Дархан-Уул | 30 | 21 | - | 9 | 444.30 | 78 | 75 | - | 3 | 1,158.10 |
| 8 | Дорноговь | 13 | 13 | - | - | 144.90 | 18 | 18 | - | | 149.00 |
| 9 | Дорнод | - | - | - | - | - | - | - | - | - | - |
| 10 | Дундговь | 59 | 59 | - | - | 137.90 | 73 | 73 | - | - | 164.70 |
| 11 | Завхан | 4 | 4 | - | - | 43.20 | 16 | 16 | - | - | 149.90 |
| 12 | Орхон | 29 | 29 | - | - | 347.80 | 31 | 31 | - | - | 362.40 |
| 13 | Өвөрхангай | - | - | - | - | - | - | - | - | - | - |
| 14 | Өмнөговь | - | - | - | - | - | - | - | - | - | - |
| 15 | Сүхбаатар | 6 | 6 | - | - | - | - | - | - | - | 38.70 |
| 16 | Сэлэнгэ | - | - | - | - | - | - | - | - | - | - |
| 17 | Төв | - | - | - | - | - | - | - | - | - | - |
| 18 | Увс | - | - | - | - | - | - | - | - | - | - |
| 19 | Ховд | - | - | - | - | - | - | - | - | - | - |
| 20 | Хөвсгөл | - | - | - | - | - | - | - | - | - | 127.20 |
| 21 | Хэнтий | - | - | - | - | - | 21 | 21 | - | - | 216.00 |
| 22 | Нийслэл | 147 | 11 | 5 | 131 | - | 182 | 180 | 2 | - | - |
| | **Нийт** | **342** | **197** | **5** | **140** | **1,534.30** | **447** | **442** | **2** | **3** | **2,862.80** |

Монгол улс, Улаанбаатар-15160, Сүхбаатар дүүрэг,
Ерөнхий сайд Амарын гудамж, Нийслэлийн өмчийн нэгдүгээр байр
Утас: +976 70007734 Факс: +976 70007734
И-мэйл: ub@audit.gov.mn, Вебсайт: www.audit.mn